

DDC
363.2
Б-342

ЦАГДАА СУДЛАЛ

*Онол арга зүйн
улирал тутмын
сэтгүүл*

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Л.Гэрэлмаа

Хэвлэлийн хуудас 5,0

Цаасны хэмжээ: В.5

Хэвлэсэн газар: Номын цацал ХХК

Дугаарыг эрхлэн гаргасан: Докторант Г.Бямбадорж

ISBN 978-99962-8882-2-7

2018 №2(21)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

Ж.Долгорсүрэн Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Б.Пүрэв Хууль зүйн доктор (Ph.D), хүндэт профессор

Ж.Заанхүү Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор

Г.Гантөмөр Хууль зүйн доктор,(Ph.D), профессор

З.Төрмандах Хууль зүйн доктор (Ph.D)

Т.Оюунчимэг Хууль зүйн доктор (Ph.D), профессор

Ж.Мөнхболд Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Сэтгүүлийн эрхлэгч: ХСИС-ийн тэргүүн дэд захирал Б.Бат-Эрдэнэ
Хууль зүйн доктор (Ph.D), профессор

Эрхлэн гаргасан, нарийн бичгийн дарга: Докторант Г.Бямбадорж

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

Т.Бямбаа Хууль зүйн доктор (Ph.D)

О.Цэцэгмаа Хууль зүйн доктор (Ph.D)

Д.Энхжаргал Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D)

Д.Мягмарцэрэн Хууль зүйн доктор (Ph.D)

Ш.Ариунбилэг Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Манай хаяг: Хууль сахиулахын их сургууль Баян зүрх дүүрэг, Цагдаагийн Академийн өргөн чөлөө, хилчиний гудамж-1, утас 70155011, 70155039, факс 976-11-70155039 мейл хаяг: police_journal@yahoo.com

ЦАГДАА СУДЛАЛ
Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл
(дугаар, 2018 №2)

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Баянмөнх “Тэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд инноваци нэвтрүүлэх асуудал”.....4

Т.Азжаргал Цагдаагийн албаны тухай хуулийн үзэл баримтлал, хэрэгжилт анхаарах зарим асуудал.....7

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Ж.Ууганчимэг Иргэний эрх зүй дэх зар сурталчилгаа ба гэм хорын асуудал.....13

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

А.Амарсайхан Гэмт хэрэг ба улирал.....17

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Д.Цэрэнлхам Шүүхийн бие даасан байдлын үндсэн хуулийн эрх зүйн харьцуулалт20

ЭКОЛОГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Ж.Нямдулам Монголын уул уурхайн салбар дахь инноваци ба эрх зүйн орчин25

Б.Наргулан Усны хаягдалын эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад анхаарах асуудал.....29

ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Хулан Хувь хүний орлогын албан татварын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл34

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Д.Ариужин Монгол улсын мэдээллийн аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал.....39

ГАДААД ХЭЛ ДЭЭР БИЧИГДСЭН ӨГҮҮЛЭЛ НИЙТЛЭЛ

Д.Бадамцэцэг Концепция и содержание конституции монголии о правах граждан на жизнь в здоровой и безопасной среде.....41

УНШИГЧ ТАНЫ МЭДЛЭГИЙН САНД

П.Цагаандарь “Эмпатия” мэдрэмж бие хүнд хэрхэн бий болдог вэ?.....47

**“ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ИННОВАЦИ НЭВТРҮҮЛЭХ АСУУДАЛ”**

Б.Баянмөнх

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн дэд профессор, цагдаагийн хошууч

Товч агуулга

Энэхүү өгүүлэлд инновацийн тухай ойлголт, түүний онцлог шинж, гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ач холбогдолтой зарим инновацийн шинэ санаа, түүний ач холбогдлын талаар товч дурдсан болно.

Түлхүүр үгс

Шинэ санаа, гэмт хэрэг, зөрчлийн газар, шуурхай байдал

Үндсэн хэсэг

Инноваци гэдэг үгийн гарал үүслийг авч үзвэл “in nova” буюу шинээр сэдэх, санаачлах гэсэн утгатай латин үг юм. Одоо хэрэглэгдэж байгаа дээрх үгийн утга нэлээдгүй өргөн хүрээг хамарна.

XIX зууны дундуур ялангуяа Германы соёл судлаачдын бүтээлүүдэд “инноваци” хэмээх ойлголт анх орж ирсэн байдаг бөгөөд анхандаа нэгээхэн соёлын зарим нэг элементийг нөгөө талын соёлд нэвтрүүлэх утга санааг илэрхийлдэг байжээ.

Тухайн үедээ Европ маягийн ахуй амьдрал, үйлдвэрлэлийг зохион байгуулах аргыг Ази, Африкийн нийгэмд нэвтрүүлэх тухай яригддаг байж.

XX зууны эхээр австрийн эрдэмтэн И.Шумпетер, Оросын эрдэмтэн Н.Кондратьев нар “эдийн засгийн хөгжилд шинэчлэл, өөрчлөлт оруулах замаар хямралыг даван туулах хэрэгсэл...” гэсэн утгаар ашигласан нь үндсэн утгаа одоо хир нь алдаагүй л байгаа.

Энэ ойлголт хожим шинжлэх ухаан, технологийн салбарт мөн үйлдвэрлэл, үйлчилгээний талбарт ч мөн ялгаагүй хэрэглэгдэх болсон билээ.

Орчин үед “Инноваци” /innovation/ гэсэн ойлголт ерөнхий утгаараа “шинэчлэх” гэсэн утга санааг илэрхийлж байна.

Инноваци нь товчоор томъёолбол ямар нэгэн бүтээлч санаанаас бодит мэдлэгийг бий болгох, түүнийгээ үйлдвэрлэл үйлчилгээнд хэрэглэгдэх, өрсөлдөх чадвар бүхий шинэ бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээ, шинэ арга зүй, менежмент болгох үйл ажиллагаа гэж ойлгож болно.

Инновацийг хэмжих үндсэн шинжүүд /шалгуурууд/ нь:

- Шинжлэх ухаан, технологийн хувьд шинэлэг байх;
- Практикт хэрэгжихүйц;
- Зах зээлд арилжаалагдах шинжтэй байх;

Энэ бүх чанараараа нийгмийн тодорхой эрэлт хэрэгцээг хангаж байж чадахуйц байх явдал юм. Өөрөөр хэлбэл шинэ бүтээгдэхүүн, эсвэл шинэ процесст шингэж бүтээгдсэн шинэлэг санаа л “инноваци” болж байна.

Инновацийг бүтээлч шинэ санаа, шинэчлэл гэсэн ойлголтуудтай хольж ойлгох хандлага элбэг байдаг. Ялгааг нь авч үзвэл:

- Бүтээлч шинэ санаа /creativity/ - Энэ нь шинэ санаа, сэдэл, төсөөллийг бий болгохыг хэлнэ. Нээлт, зохион бүтээлт, патент, бүтээгдэхүүний тэмдэг, шинэ санаагаа саналын хэлбэрээр илэрхийлэх, шинэ юмуу боловсронгуй болгосон бүтээгдэхүүн, стандарт,

зөвлөгөө, аргачлалын хэлбэрээр, зах зээлийн судалгааны үр дүнгийн хэлбэрээр тус тус илэрдэг.

- Инноваци - Шинэ сэдлээ бодит бүтээгдэхүүн, үйлчилгээ болгох явц нь юм. Шинэ зүйл хийхийн тулд маркетингийн судалгаа, эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажил явуулж, үйлдвэрлэлийн зохион байгуулалт- технологийн бэлтгэл ханган үр дүнг тодорхойлдог. Ингэсний дараа объектыг өөрчлөн шинэчлэх, тодорхой үр дүн гаргах зорилгоор шинэ зүйлийг нэвтрүүлсний эцсийн үр дүн нь инноваци байна.
- Шинэчлэл /reform/ - Макро түвшний өргөн хүрээг хамарсан өөрчлөлт шинэчлэлтийг хэлнэ.
- Инноваци - микро түвшинд өрнөж буй шинэчлэлүүдийн тухай ойлголт юм.¹

Иноваци нь улс орны хөгжлийн явцад үүсдэг зөрчил, үл ойлголцлын асуудлыг шийдвэрлэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хэрэгжүүлж иргэдийн амьдралыг өөрчлөхийн тулд олон талын шинэчлэлийг эхлүүлэх эх үндсийг бий болгодог байна.

Өнөөдөр бид гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд иновацийг хэрэгжүүлэхдээ гадны орнуудын хууль сахиулах салбарт хийгдсэн, түүнийг практикаар туршигдаж тодорхой үр дүнд хүрсэн технологийн ололтыг өөрийн орны онцлог шинжид тулгуурлан, хөрсөнд сайтар нутагшуулж хийх ёстой. Гэхдээ монгол соёл уламжлал, сэтгэлгээ, ахуйд нийцүүлсэн байх ёстойг анхаарах нь зүйтэй болов уу.

Ер нь уул уурхай, хууль зүй гээд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарын хөгжлийн түлхүүр нь эцэстээ хүний хөгжил байдаг. Гадны туршлагыг ашиглахдаа үндэсний шинжийг хадгалахын зэрэгцээ даяаршиж буй дэлхийн чиг хандлагаас гажих ёсгүйг сайтар ухамсарласан байх ёстой.

Анзаараад байхад аливаа үйл ажиллагаанд иновацийг хүлээж авах нийгмийн сэтгэл зүй их чухал байдаг нь хууль зүйн салбарт хийж байгаа шинэчлэлийн үйл явцаас харагдана. Энэ нь тухайн салбарт нь ажиллаж байгаа хүмүүсийн сэтгэл зүйн хандлага хэр сайн өөрчлөгдсөнөөс ихээхэн хамаарч, шинэчлэлийн үр дүн тодорхойлогдоно..

Энэ удаа гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд инноваци нэвтрүүлэх нь гарсан гэмт хэргийг нэн даруй таслан зогсоох, хор уршгийг нэмэгдүүлэх байлгах, түргэн шуурхай илрүүлэхэд ач холбогдолтой гэж үзсэний үндсэн дээр дараах 2 инновацийн санаа гаргаж байна. Үүнд:

1. Мэдээлэлтэй цагдаагийн алба хаагч;
2. Хамгаалалтын бүтээлэг;

Нэг. Мэдээлэлтэй цагдаагийн алба хаагч.

Энэ инновацийн санаа нь нийт алба хаагчдад яаралтай хүргэх нэн шаардлагатай мэдээллийг цахилгаан холбоо болон олон нийтийн цахим сүлжээ, мэдээллийн бүх суваг ашиглах замаар шуурхай хүргэх явдал юм.

Өөрөөр хэлбэр гар утас нь холбогдохгүй тохиолдолд түүний нэр, цахим хаягтай бусад бүх сүлжээгээр тухайн мэдээлэл очих явдал юм.

Цагдаагийн байгууллагын бүх алба хаагчид энэ цахим сүлжээнд холбогдсон байх шаардлагатай. Үүнийг цагдаагийн байгууллагын Мэдээлэл, шуурхай удирдлагын төв хариуцан зохион байгуулж мэдээлэл хүргэгдэнэ. Энэ инновацийн санааг хэрэгжүүлэхийн тулд дараах ажлуудыг хийсэн байх ёстой. Үүнд:

1. Цагдаагийн нийт бие бүрэлдэхүүн бүгд цахим мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамрагдсан байна.
2. Алба хаагчдад хүргэх мэдээллийг дотор нь ангилах замаар мэдээллийн ялгамжтай байдлыг гаргасан байх шаардлагатай.

Мэдээллийг:

- а. Ач холбогдолоор нь
 - Маш яаралтай
 - Яаралтай

¹//mlctraining.mn/innovation-gej-yu-ve/#sthash.HEEhWlhm.dpuf

- Яаралтай бус
- б. Хамрах хүрээгээр нь:
 - Нийт бие бүрэлдэхүүнд;
 - Зөвхөн тодорхой нэг албаны алба хаагчид;
/Замын цагдаагийн алба, Мөрдөх алба, Эрүүгийн цагдаагийн алба гэх мэт/
 - Тодорхой нутаг дэвсгэрийн цагдаагийн алба хаагчид;
/аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтэс, тасаг, нэгж/
 - Зөвхөн сонгогдсон алба хаагчид;
/тодорхой зорилгын хүрээнд/
 - Офицер, ахлагч бүрэлдэхүүнээр нь;
- 3. Мэдээлэл хүргэх цагдаагийн алба хаагч сүлжээнд орж мэдээлэл аваагүй тохиолдолд түүний хамгийн ойр байх гэр бүлийн насанд хүрсэн гишүүний цахим хаягаар холбогдож, мэдээлэл хүргэх арга хэмжээ авах байдлаар зохицуулалт хийсэн байна.
/аав, ээж, ах, эгч, дүү, эхнэр, насанд хүрсэн хүүхэд гэх мэт/
- 4. Мэдээлэл дамжуулах сүлжээний эх үүсвэр нь Мэдээлэл, шуурхай удирдлагын төв байна.
- 5. Хэрэв цагдаагийн алба хаагч ээлжийн амралт, өвчтэй, чөлөөтэй байгаа тохиолдолд тухайн алба хаагчийн мэдээллийн сувгийг чагталж, бусад алба хаагчид хүргэнэ.

Хоёр. Хамгаалалтын бүтээлэг.

Гэмт хэрэг, зөрчлийн талаархи дуудлага, мэдээллийг хүлээн авч, хэргийн газарт очсон цагдаагийн алба хаагчдад нэг тулгардаг нэг хүндрэл бэрхшээл бол байгалийн болон цаг үеийн шинжтэй нөхцөл байдлаас шалтгаан гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах асуудал хурцаар тавигддаг.

Гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалахад цагдаагийн алба хаагч гарын доорхи материал ашиглан хамгаалдаг бөгөөд тэр болгон ашиглах материал олдохгүй, ул мөр балрах асуудал багагүй гардаг бөгөөд үүнийг шийдвэрлэхэд энэ инновацийн санаа чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

“Хамгаалалтын бүтээлэг” бол гэмт хэрэг, зөрчлийн газрын төв хэсэг буюу хамгийн гол чухал ул мөрийг хамгаалах зориулалттай, агаар, ус нэвтрүүлдэггүй, гялгар материалаар хийгдсэн байх бөгөөд бүтээлэг нь 4х4 м хэмжээтэй, 4 буланд нь агаар шуурхай дамжуулах үүрэгтэй хүндрүүлэгч байрлуулан холбосон байна.

“Хамгаалалтын бүтээлэг” нь дахин ашиглах боломжтой, эвхэгддэг, маш бага зай эзэлдэг, нийтийн хэв журам хмааалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах шууд үүрэг бүхий цагдаагийн алба хаагч нэг бүрт зайлшгүй байх ёстой хэрэгсэл байна.

“Хамгаалалтын бүтээлэг”-ийн хэмжээг 4х4, 6х6, 8х8 метрийн харьцаатайгаар хийж, бүтээлгийн 4х4 хэмжээг нь хар, 6х6 хэмжээтэйг нь хөх, 8х8 хэмжээтэйг нь ногоон өнгөөр тус тус ялгамжтай байдлаар хийнэ.

Энэ нь тухайн гэмт хэрэг, зөрчлийн газарт үлдсэн ул мөрийн тархалт, зайлшгүй хамгаалах ёстой эд зүйлүүдийг хамгаалах зорилгоор харилцан адилгүй байдлаар сонгон авч хамгаалалтыг хийх бөгөөд ямар хэмжээтэй хамгаалалтын бүтээлэг ашиглахыг хэргийн газарт түрүүлж очсон цагдаагийн алба хаагч тухайн нөхцөл байдлыг үнэлэн өөрөө бие даан шийдвэр гарган зохион байгуулна.

Дүгнэлт. “Мэдээлэлтэй цагдаагийн алба хаагч”, “Хамгаалалтын бүтээлэг” гэсэн 2 инновацийн санаан тулгуурлан ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төв болон Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхим хамтран ажлын хэсэг байгуулан, иж бүрэн суурь судалгаа хийж, практикт нэвтрүүлэх ажлыг бодлогын хэмжээнд авч хэрэгжүүлж чадвал цагдаагийн алба хаагчдад мэдээ, мэдээлэл шуурхай хүрч, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч, хэргийн газарт үлдсэн ул мөрийг найдвартай хамгаалж чадсанаар гэмт хэрэг, зөрчлийг түргэн шуурхай илрүүлэх, гарч болох хор уршгийг нэмэгдүүлэхгүй байх боломж нөхцөл нэмэгдэнэ.

Санал. Дээрхи бүгдийг нэгтгэн авч үзээд “Мэдээлэлтэй цагдаагийн алба хаагч”, “Хамгаалалтын бүтээлэг” инновацийн санааг практик хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. үүнд:

1. ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төв болон Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхим хамтран “Мэдээлэлтэй цагдаагийн алба хаагч”, “Хамгаалалтын бүтээлэг” инновацийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулан, төсөл боловсруулж, “Нээлттэй нийгэм форум”-д хүргүүлэх;
2. Цагдаагийн нийт бие бүрэлдэхүүнд мэдээ, мэдээлэл хүрч байгаа эсэхэд магистрын түвшинд судалгаа хийж, түүний шалтгаан нөхцлийг тодруулах;
3. Гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд инноваци нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай объектуудыг судлан гаргаж ирэх;
4. Гадаадын орнуудын цагдаагийн байгууллагад хэрэгжүүлсэн инновацийн туршлагаудыг судалж, өөрийн орны хөрсөнд буулган нэвтрүүлэх арга хэмжээг авч эхлэх;

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМЛАЛ, ХЭРЭГЖИЛТ АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Т.Азжаргал

ХСИС-ийн Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн
Эрх зүйн онолын тэнхимийн багш, ахмад

Товч агуулга

Цагдаагийн байгууллага нь хууль сахиулах, захиргааны, цэргийн аль байгууллага байхаас үл хамааран Үндсэн хуулиар тодорхойлсон чиг үүрэг хэвээр хадгалагдана. Эрх зүйн шинэтгэлийн үр нөлөө нь энэ байгууллага ямар байгууллага байхад биш харин Цагдаагийн байгууллагад алба хааж байгаа цагдаагийн алба хаагчийн эрх, түүний баталгааг бүрдүүлэх нь байгууллагын чадавхтай холбоотой юм. Учир нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чадавхыг цагдаагийн алба хаагчийн хөдөлмөрийн аятайнөхцөлөөрхангуулах, цалинхөлс авах, амрах эрхийн баталгаагаар тодорхойлдогбөгөөд хөдөлмөрлөх үйл ажиллагааны хэрэгжилтээс ажлын үр дүн нь ихээхэн шалтгаалдаг байна. Тухайлбал энэ байгууллагын алба хаагчийн хөдөлмөрийнбаятайнөхцөлөөрхангуулах, цалинхөлс авах, амрах эрх, үйл ажиллагааны чадавхи хоёр нь нэг зоосны хоёр тал юм гэдгийг зайлшгүй анхаарах шаардлага байна.

Түлхүүр үг

Цагдаагийн байгууллага, хууль сахиулах байгууллага, цагдаагийн алба хаагч, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрх, цалин хөлс авах эрх, амрах эрх

Монголчуудын уламжлалт төрийг дээдлэх үзэл хандлага марксист номлолын нөлөөгөөр эрх зүй, хууль хоёрыг адилтгах үзэл хууль тогтоох ажиллагааг суурь стандартаас хөндийрүүлж төрийн хүсэл зориг мэтээр хандах зэрэг эрх зүйн соёл, сэтгэлгээний өнөөгийн онцлог нь эрх зүйт ёсны шинэ соёл, үндсэн хуульт ёсыг төлөвшүүлэхэд харгалзан үзэх үндэсний хүчин зүйл мөн.

Монгол улсад 1990 оны ардчилсан хувьсгалийг хуульчлан бэхжүүлсэн Үндсэн хуулийг 1992 онд баталж тус улсын зорилгын туйлыг эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан байгуулах явдал гэж тунхаглажээ. Хүний эрх эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, нийгэм улс төрийн тогтолцоог ардчилж хувийн болон нийтийн өмчийн аливаа хэлбэрийн тэгш эрхийг баталгаажуулсан, зах зээлийн харилцааг хөгжүүлсэн, хүн төрөлхтөний хөгжлийн түгээмэл зүй тогтолд нийцсэн, нийгмийг байгуулах асуудал МУ-ын шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалын тулгуур суурь нь юм.

МУ-сад шинэ Үндсэн хуулиа баталсанаас хойш хорин зургаан жилийн хугацаанд уг хуульд нийцүүлэн нийгмийг жолоодон зохион байгуулах гол хүч төрийн байгууллагын зохион

байгуулалт үйл ажиллагааг ардчилах, нийгмийн харилцааг зохицуулах үндсэн хэрэгсэл эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх талаар олон ажил хийсэн боловч өнөөдрийг хүртэл үргэжилж л байна.

Энэ хүрээнд Монгол улсын цагдаагийн байгууллагын тухай хууль, УБ., 1993 он, №8-ийг батлан энэ байгууллагын эрх зүйн үндэс, статус, алба хаагчийн эрх зүйн байдал зэргийг тодорхойлон баталж, уг хууль нь хорин жилийн хугацаанд үүргээ гүйцэтгэсэн юм.

Энэ хугацаанд 2002 онд эрх зүйн шинэтгэлийн үр дүнд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, түүнтэй холбогдох бусад хууль тогтоомжийг шинэчлэн баталсан бөгөөд үүнийг МУ-д хийгдсэн эрх зүйн шинэтгэлийн хоёр дах давалгаа гэж үзэж болох юм.

Эрх зүйн шинэтгэлийн гурав дах давалгаа нь нийгмийн хөгжлийн олон үе шатуудад хууль зүйн салбар тэр дундаа хууль сахиулах үйл ажиллагаа эрх зүйн нэгдсэн зохицуулалтгүй явж ирсэн, цагдаа прокурор шүүх эрх мэдлийн тогтолцоог төвлөрүүлэх замаар шийдвэр гаргах ажиллагааг хэрэгжүүлдэг, дээд шатны байгууллагаас доод шатандаа тушаасан хөшүүн систем салбар дотроо буй болгосон зэргийг судалгаагаар тогтоон²гэмт хэрэг илрүүлэх хойшлуулшгүй ажиллагаа, иргэний өмч хөрөнгийг битүүмжлэх, хураан авах, нэгжих, үзлэг хийх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах буюу нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх гүйцэтгэх ажил, нийгмийн хэв журам сахиулах, нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанууд “Хууль сахиулах үйл ажиллагаа” гэсэн ойлголтод багтана хэмээн үзэж Улсын Их Хурлаас 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Цагдаагийн албаны тухай хуулийг баталж, улмаар 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд түүнтэй холбогдох Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг боловруулсанаар эрх зүйн шинэтгэлийн гуравдахь давалгаа эхлэв.

Дэлхийн улс орнуудын практикаас харахад хууль сахиулах үйл ажиллагаа нь нилээн өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд үүний нийт иргэдэд шууд мэдрэгдэх хууль сахиулах аюулгүй байдлын хосолсон шинжтэй үйлчилгээг цагдаагийн байгууллага гүйцэтгэдэг бөгөөд тухайлбал цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хоёрны нэг нь иргэнд үйлчилдэг захиргааны байгууллагын шинжтэй нөгөө хэсэг нь хууль сахиулах хууль сахиулах чиг үүргийг гүйцэтгэдэг шинжтэй байгааг үндэслэн 2013 оны Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн байгууллагыг “Хууль сахиулах байгууллага” хэмээн тодорхойлжээ.³

Хууль сахиулах байгууллага гэдэг нь: Хууль зүйн хариуцлагыг тогтоосон хуулиудыг зөрчсөн үйлдэл, түүнийг үйлдсэн хүнийг илрүүлэх таслан зогсоох шийтгэл хүлээлгэх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн албадлагын шинжтэй үйл ажиллагаа явуулах тогтолцоог хэлэх⁴ бөгөөд Цагдаагийн албаны тухай 2013 оны хуулиар цагдаагийн байгууллага хууль сахиулах байгууллага, түүний алба хаагчийг хууль сахиулагч гэж тодоройлж эрх зүйн үндсийг бүрдүүлж, энэ байгууллагын цаашдын чиг хандлага ч мөн хууль сахиулах байгууллагын хүрээнд баримжаалсан байсан. Тухайлбал цагдаагийн байгууллагыг иргэнд аюулгүй байдлын үйлчилгээг үзүүлдэг учраас цэргийн байгууллагаас ялгах шаарлагатай хэмээн үзэж хууль сахиулан чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын иргэнд үйлчлэх үүргийг тодорхой хэмжээнд гаргаж эрх зүйн шинэтгэлийг хийсэн боловч цэрэгжсэн байгууллага гэсэн ойлголтоос нь салгаж чадаагүй юм.

Цагдаагийн байгууллагыг хууль сахиулах байгууллага болгох тодорхой тохиолдол кейс үүссэн гэж үзсэн. Тухайлбал 2008 оны 7 сарын 1-ний хэрэг явдлын дараагаар цагдаагийн удирдлагыг уг үйл явдлын улмаас хүний амь нас үрэгдсэн явдалд гэм буруутай эсэхийг шүүхээр шийдвэрлэх үед өмнө нь бид цэрэгжсэн байгууллага байсан учраас тушаалаар хөдөлдөг гэсэн

²Эрүүгийн эрх зүй дэхь судалгааны илтгэл, Франц улс, Страсбург хот 2009 он, 8 дахь тал, Швецарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Иргэдийн Альянс Төвийн орчуулга, ХЗҮХ-ээс 2009, 2009 онуудад явуулсан “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгааны дүнгээс, http://www.icac.nsw.gov.au/files/pdf/pub2_5q1.pdf-ийг үзнэ үү

³Цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2013, ТМ №29, 3.1. 3.1.Цагдаагийн албаныгэмтхэрэгтэйгэмцэх, нийтийнхэвжуррамхамгаалах,

олоннийтийнаюулгүйбайдлыгхангахүндсэнчигүүрэгбүхийхуульсахиулахбайгууллагамөн.

⁴Хууль зүйн англи хэлний толь Black’s Dictionary

ойлголттой байсан боловч яг шүүхээр хэрэг шийдвэрлэх явцад бид иргэнд үйлчилдэг байгууллага болхоор цэргийн гэмт хэргээр зүйлчлэхгүй хэмээн маргаж байв.⁵

Гэхдээ цагдаагийн байгууллага цэргийн байгууллага биш юм бол бас захиргааны байгууллага ч бас биш юм. Иймээс ямар байгууллага байх ёстой вэ гэдэг асуудал хөндөгдсөн. Иймд бид цэргийн болон иргэний байгууллагын дунд “Хууль сахиулах байгууллага” гэсэн шинэ статус байх ёстой гэж үзсэний үндсэн дээр, тийм шаардлагаар эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

Учир нь цагдаагийн байгууллага нь хууль сахиулах үйл ажиллагааг явуулахдаа иргэнлүүгээ хандсан зорилго илүү тодорхой харагдаж байдаг хууль сахиулах чиг үүрэгтэй байгууллага болохоос цэргийн байгууллага биш гэсэн гаргалгааг гаргаж иржээ. Тухайлбал нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэргийн талаарх өргөдөл гомдлыг шийдвэрлэх үедээ иргэнд үйлчилдэг байна. Гэмт хэрэгтэй тэмцэх илрүүлэх болон таслан зогсоох, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах буюу нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх таслан зогсоох хязгаарлах үед хууль сахиулах чиг үүргээ биелүүлдэг байгууллага байна.

Гэвч хууль үйлчлээд тодорхой хугацаа өнгөрөхөд хуулиар зохицуулагдаагүй харилцаа үүсч, хууль сахиулах зарим процедур тогтоосон хэм хэмжээ дутагдалтайн⁶ улмаас эрх зүйн хийдэл гарч эхэлсэн бөгөөд уг хуулийг хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлийг арилгах, цагдаагийн албаны үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, цагдаагийн алба хаагчийг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх, зөвхөн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор зайлшгүй тохиолдолд хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд хүний эрх, эрх чөлөөнд халдах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2017 он, ТМ №8-ийг шинэчлэн боловсруулж баталсан.

Учир нь хууль тогтоох эрх мэдэл гэдэг нь төрийн бодлогыг тодорхойлж, нийгмийн харилцааг зохицуулахын тулд ард түмний өмнөөс хууль тогтоомжийн акт гаргаж, түүнийгээ гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа байдлыг хянан шалгаж дэмжих замаар улсыг хуулиар жолоодох үйл ажиллагааг бүхэлд нь хэлнэ. Иймээс хууль бол төрийн бодлогын хэмжүүр юм. Тиймээс Монгол улсын Үндсэн хуулийн арван нэгдүгээр зүйлийн 11.2-т заасныг үндэслэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бодлогыг хуулиар тодорхойлжээ.⁷

Монгол улсад хийгдсэн эрх зүйн шинэтгэлийн үр дүнд Цагдаагийн байгууллагыг хууль сахиулах байгууллага гэж Цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2013, ТМ №29-д тодорхолж гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээг толорхойлсон бол Цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2017 он, ТМ №8-ийн зохицуулалтаас харахад төрийн тусгай алба бөгөөд цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал баталгаагаар хангагдсан Монгол улсын ерөнхийлөгч, зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн⁸ зарлигаар цол олгох журмыг хугацааны дагуу тодорхойлсон цэргийн байгууллага болгон тодорхойлжээ.

Үүний нэг хүчин зүйл нь Дотоодын цэргийн тухай хууль, УБ., 2017 он, ТМ №12-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт “... дотоодын цэрэг” гэж дотоодын цэрэгт алба хааж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг; 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “...

Дотоодын цэргийн командлагч батлах”-аар зохицуулсанаас харахад дотоодын цэрэг болон цагдаагийн байгууллагын чиг үүргийг ялган зааглаж зохицуулжээ. Гэсэн хэдий ч цагдаагийн алба хаагч нь цэргийн алба хаагчийн нэгэн адил эрх зүйн байдал, баталгаагаар хангагдаж байгаа бөгөөд хуулийн үзэл баримтлалын хувьд цэргийн байгууллага болох эрх зүйн үндэс бүрдсэн болохыг харуулж байна.

⁵“Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт чиг хандлага” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл-II, УБ., 2013 он, 222 дахь тал

⁶Тухайлбал, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль зэрэг Цагдаагийн албаны тухай хуулийг дагалдаж гарах хуулиуд батлагдаагүй юм.

⁷Монгол улсын Үндсэн хууль, УБ., 1992 он, ТМ №1-ийн арван нэгдүгээр зүйлийн 2-дахь хэсэгт “...Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно” гэжээ.

⁸Монгол улсын Үндсэн хууль, УБ., 1992 он, ТМ №1, 33.2-т Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна хэмээн тодорхойлжээ.

Цагдаагийн байгууллагыг хууль сахиулах байгууллагаас цэргийн байгууллага уруу шилжиж байгааг нотлох эрх зүйн өөрчлөлтүүдээс дурдвал:

Хуулийн зорилт нь “Монгол Улсын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтооход оршино. Цагдаагийн алба хаагч нь хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан нийтлэг эрх үүргийг хэрэгжүүлнэ гэснийг Цагдаагийн албаны тухай хуульд заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ, Цагдаагийн төв байгууллагын дарга нь дотоодын цэргийн командлагч байна” гэх мэт олон үзэл баримтлалын шинжтэй өөрчлөлт орсон.

Гэвч Цагдаагийн байгууллагад хийгдсэн эрх зүйн шинэтгэлээс дүгнэвэл хууль тогтоогчоос хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд хуулиар дамжуулан энэ байгууллагын бодлогыг тодорхойлж байгаа боловч цагдаагийн байгууллагын эрх зүйн үндсийг үйл ажиллагааны чиглэлийг Монгол улсын Үндсэн хуулийн арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...*Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн*”, арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “*Төрөөс ... хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.*” гэж заасан нь цагдаагийн байгууллагыг төрийн нэрийн өмнөөс Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн дэг журмыг хангах, хүний эрх, эрхчөлөөг зөрчихтэй тэмцэх, үүргийг хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны эрх зүйн үндсийг зааж өгсөн бөгөөд аль ч эрх зүйн шинэтгэлийн үед цагдаагийн байгууллагын энэ чиг үүрэг хэвээр хадгалагдаж ирсэн.

Тиймээс цагдаагийн байгууллага ямар байгууллага байхаас үл хамааран Үндсэн хуулиар тодорхойлсон дээрхи чиг үүрэг хэвээр хадгалагдана.

Эрх зүйн шинэтгэлийн үр нөлөө нь энэ байгууллага ямар байгууллага байхад биш харин Цагдаагийн байгууллагад алба хааж байгаа цагдаагийн алба хаагчийн эрх, түүний баталгааг бүрдүүлэхэд чиглэх ёстой юм.

Учир нь ***Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чадавхыг цагдаагийн алба хаагчийн хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, эрхийн баталгаагаар тодорхойлдог*** бөгөөд энэхүү эрхийн хэрэгжилтээс үйл ажиллагааных нь үр дүн ихээхэн шалтгаалдаг байна.

Тухайлбал энэ байгууллагын алба хаагчийн хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбогдсон эрх, үйл ажиллагааны чадавхи хоёр нь нэг зоосны хоёр тал юм гэдгийг зайлшгүй анхаарах шаардлага байна.

Цагдаагийн байгууллага нь хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалж, урьдчилан сэргийлж, хүний аюулгүй, амар тайван амьдрах баталгааг бүрдүүлэх чиг үүрэгтэй бөгөөд тус байгууллагад үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын хөдөлмөрлөх үйл ажиллагаатай нь холбоотой эрх зөрчигдөх эрсдэл өндөртэй бүлэгт хамаардагтул ХЭҮК-оос “МУ дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 14 дэх илтгэл” УБ., 2015 он тайлан илтгэлийн хүрээндхяналт шалгалт, судалгаа хийсэн байна.

Сүүлийн жилүүдэд цагдаагийн байгууллагыг “*хүний эрхийг зөрчигч*” гэж тооцох, хандах болсноор тэдний хууль ёсны шаардлагыг үл тоох, бие махбодод халдах, заналхийлэх үзэгдэл гарсаар байна.

Хүний эрхийг хамгаалж байгаа цагдаагийн байгууллагын албан хаагчдын эрх дараах байдлаар зөрчигддөг байна. Үүнд:

Нэр төр, алдар хүнд, бие махбодод нь халдах, заналхийлэх; Хөдөлмөрлөх, ажил үүргээ гүйцэтгэхэд саад болох; Сэтгэл зүйн дарамт үзүүлэх; Үндэслэлгүйгээр эрх зүйн хариуцлага тооцох, тооцохоор заналхийлэх хэлбэртэй байна.

“Хүний эрхийг хамгаалагчийн эрхийн хэрэгжилт” судалгаанд хамрагдагсдын 50 хувь нь Монгол Улсад хүний эрх хамгаалагчийн “аюулгүй байдал хангалтгүй”, 30 хувь нь “дунд зэрэг хангагдсан” гэж үнэлсэн бол 20 хувь нь “аюулгүй байдал хангагдсан” гэж хариулсан байна.

Аюулгүй байдал хангалтгүй гэж хариулсан хүмүүс “эрх зүйн орчин бүрдээгүй”, “доромжлол, гүтгэлэгт өртдөг”, “аюулгүй байдал хангагдаагүй”, “хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломжгүй” гэсэн шалтгааныг дурджээ.

Ярилцлагад оролцогчид хүний эрхийг хамгаалагчийн эрх зөрчигдөхөд дор дурдсан хүчин зүйл нөлөөлдөг гэж үзжээ. Үүнд:

- Хууль сахиулах байгууллагуудад улс төрийн нөлөөлөл бий болсон;
- Хэвлэл мэдээллийн байгууллагын хариуцлагагүй байдал;
- Төрөөс хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах бодлого, эрх зүйн зохицуулалт хангалтгүй;
- Хүний эрхийг хамгаалагчийн ажлын ачаалал их гэж дурдсан байна.

Ярилцлага:

Хууль сахиулах байгууллагуудад улс төрийн нөлөөлөл орж, хэт улс төржүүлснээс ажилтнуудын эрх зөрчигдөж байна. Хуулийн шинэчлэл нэрийдлээр өөр хоорондоо зөрүүтэй, зөрчилтэй хууль батлан гаргаснаас хэн нь юу хийх нь тодорхойгүй болж, улс төрийн томилгоо хийсэн нь албан хаагчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж байна. Цагдаагийн байгууллага улс төржилтгүй үед хүчтэй байсан, одоо бол сүр хүчгүй байна.

Судалгаагаар хүний эрхийг хамгаалагчийн эрхийг хэн, хэрхэн зөрчиж байгааг тодруулахад улс төрчид, улс төрийн нам, бүлэглэл, эрх баригчид болон төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, хэргийн оролцогч, шүүхийн шийдвэрээр эрхээ хязгаарлуулсан этгээдийн гэр бүлийн зүгээс зөрчдөг гэсэн байна.⁹

Судалгааны баримтаас үзвэл Монгол Улсад хүний эрхийг хамгаалагчийн эрхийг зөрчих явдал нийтлэг бөгөөд олон талтай байдгаас тэдний эрх зөрчигдөж буй байдлыг нэгдсэн тоон үзүүлэлтээр гаргах боломжгүй байна.

Цагдаагийн алба хаагчийн ажлын ачааллыг зүй зохистой байлгах, ажлын чанарыг сайжруулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд Монгол улсын Засгийн газраас 2011 оны 153 дугаар тогтоолоор “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг нормативыг тогтоосон бөгөөд дурдвал:

4000 хүн ам тутамд 1 хэсгийн байцаагч, Хэв журмын эргүүл нийслэлд 15 000 хүн ам тутамд хоёроос доошгүй, Аймгийн төвд 5 000 хүн ам тутамд нэгээс доошгүй, Эргүүлийн нэг чиглэлд хоёр албан хаагч үүрэг гүйцэтгэхээр заажээ.

Дүгнэвэл: Улсын хэмжээнд орон тоог 2175 офицер, 1138 ахлагч, 104 энгийн ажилтан буюу нийт 3417 алба хаагчаар нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд, **нийслэлд нийт** 962 офицер, 346 ахлагч, 61 энгийн ажилтны орон тоо нэмэгдүүлэх, **орон нутагт нийт** 1213 офицер 792 ахлагч, 41 энгийн ажилтны орон тоо нэмэгдүүлэх тооцоо гарсан байна.

Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажилтан өдөрт 8 цаг буюу 7 хоногт 40 цаг, сард 160 цаг, жилд 1760 цаг ажиллах ёстой.


Гэтэл нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий алба хаагч 7 хоногийн 6 өдөр буюу хамгийн багадаа сард 192 цаг, жилд 2112 цаг ажиллаж, нийт **352** цагийн илүү үүрэг гүйцэтгэж ажиллаж байна./ *Жич: Үүнд шуурхай цугларалт, албаны бэлэн байдал, хүчлэн хамгаалалт зэрэг онцлог цаг үеэр ажиллуулсныг тооцоогүй болно.*/

Замын цагдаагийн алба хаагч жилд дунджаар 2288 цаг ажиллаж, үүнээс 528 цагийн илүү үүрэг гүйцэтгэж ажиллаж байна.

Шөнийн ээлжинд ажилласан алба хаагч сард 188, жилд 2068 цагийн илүү үүрэг гүйцэтгэж ажиллаж байна.

График №1. Цагдаагийн алба хаагчдын ажлын цаг

⁹ХЭҮК “МУ дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 14 дэх илтгэл” УБ., 2015 он, 56 дахь тал



Цагдаагийн ерөнхий газраас нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг нэг загвараар баталсан бөгөөд үүнд илүү цагаар ажиллах шаардлага тусгасан нь Төрийн албаны тухай хууль зөрчиж байна.

Орон тоо цөөн учир нийтийн хэв журам хамгаалах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчид нь байнга өндөрчаалалтай, илүү цагаар ажилладаг тул сургалт, соён гэгээрүүлэх ажилд хамрагдаж чаддаггүй. Мөн ажлын үр дүн, хариуцлага, ёс зүй, харилцаа хандлага, гэр бүлийн байдалд нь шууд болон шууд бусаар сөрөг нөлөө үзүүлдэг талаар цагдаагийн албан хаагчдын олонх нь дурдсан болно.

Дүгнэлт

Энэ бүгдээс үзэхэд орон тоо дутмаг учраас цагдаагийн алба хаагчид илүү цагаар ажиллаж байх бөгөөд төсөв хүрэлцээгүйн улмаас илүү цагаар, амралтын болон баярын өдөр ажилласан цалинг олгохгүй байгаа нь хөдөлмөрлөх эрхийг зөрчиж байна. Тэгэхдээ Цагдаагийн албаны тухай хууль 2017 он, ТМ №8-д цагдаагийн алба хаагчийн эдийн засаг, хууль зүй, улс төр, нийгмийн баталгааг хангагдахуйц байдлаар тусгаж өгсөн бөгөөд зөвхөн байгууллагын удирдлагаас хуулийг хэрэгжүүлэх тал дээр учир дутагдалтай болох нь харагдаж байна.

Тухайлбал: ЦАТХ-ийн 88.4-т “...Нийтийг хамарсан эмх замбраагүй байдал, гамшиг, хорио цээрийн дэглэм сахиулах болон онц байдлын үед үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчийн албан тушаалын цалинг ажилласан цаг тутамд хоёр дахин нэмэгдүүлж олгоно.”, 90.2-т “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшилыг таван жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшил олгох журмыг Засгийн газар батална”, 87.8-д “Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь гэмтэл учирснаас нас барсан, эсхүл албанаас чөлөөлөгдсөн иргэнийг урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулсан бол энэ хуулийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тусламж олгоно”, 87.4-д “Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрээр ажилласан нэг жилийг нэг жил гурван сараар, цагдаагийн байгууллагын нууцлал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сараар тус тус тооцно” гэх мэтчилэнгээр эрх зүйн байдлыг дээрдүүлсэн маш олон зохицуулалт тусгагджээ.

Монгол улсад хийгдсэн эрх зүйн шинэтгэлийн үр дүнд Цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2017 он, ТМ №8-ийн зохицуулалтаас харахад цагдаагийн байгууллага нь төрийн тусгай алба бөгөөд цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал баталгаагаар хангагдсан Монгол улсын ерөнхийлөгч, зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зарлигаар цол олгох журамд заасан хугацааны дагуу тодорхойлсон цэргийн байгууллага болгон тодорхойлжээ.

Мөн цагдаагийн байгууллагад дотоодын цэргийн байгууллага байх бөгөөд дотоодын цэрэг болон цагдаагийн байгууллагын чиг үүргийг хуулиар ялган зааглаж зохицуулжээ. Гэсэн хэдий ч цагдаагийн алба хаагч нь цэргийн алба хаагчийн нэгэн адил эрх зүйн байдал, баталгаагаар хангагдаж байгаа бөгөөд хуулийн үзэл баримтлалын хувьд цэргийн байгууллага болох эрх зүйн үндэс бүрджээ.

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ЗАР СУРТАЛЧИЛГАА БА ГЭМ ХОРЫН АСУУДАЛ

Ж.Ууганчимэг

Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн эрх зүйн
онолын тэнхимийн ахлах багш, ахлах дэслэгч

Товч агуулга

Монгол Улс чөлөөт зах зээлийн нийгэмд шилжсэнээр хүн бүр чөлөөтэй аж ахуй эрхлэн явуулах боломжтой болж зар сурталчилгааны харилцаа хөгжсөн. Үүнийг зар сурталчилгааны болон бусад мэдээллийг хүлээн авах боломж бололцоо үлэмж нэмэгдэхийн хэрээр зар сурталчилгааны төрөл олширсон. Зар сурталчилганы эрх зүйн орчны талаарх байгууллага, иргэдийн мэдлэг муу байгаагаас хууль бус зар сурталчилгааг түгээх, бүтээх үйл ажиллагаа нь хяналтгүй байгаа төдийгүй, хуулийн хэрэгжилт, хариуцлагын үр нөлөө сул байгаа нь аливаа гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан нөхцөл болж байна. Түүнээс гадна “Зарын бодит үнэнийг зарлуулсан байгууллага, хувь хүн бүрэн хариуцна” гэсэн Зар сурталчилгааны тухай хууль болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг зөрчсөн “гэрээний нөхцөл” хуулиас илүү хүчин чадалтай үйлчилдэг “гаж” үзэгдэл газар авчээ. Энэхүү нөхцөл байдал нь зар сурталчилгааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, сурталчлах, хууль бус зар сурталчилгааг хамтын ажиллагааны үндсэн дээр таслан зогсоох хэрэгцээг бий болгож байгаа юм.

Түлхүүр үг

Зар, зар сурталчилгаа, мэдээллийн технологи, гэм хор, хариуцлага бараа, ажил үйлчилгээ

Үндсэн хэсэг:

Иргэний эрх зүйн үндсэн зарчмуудын нэг нь зөрчигдсэн эрхээ сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчим байдаг. Өөрөөр хэлбэл иргэний эрх зүйн харилцаанд эрх тэгш байдлаар оролцож байгаа хувь хүн, аж ахуйн нэг, байгууллага аль боловч бусдын хууль болон гэрээ зөрчиж учруулсан гэм хор, хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй байна.

Иргэний хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт зааснаар мэдээлэл нь иргэний эрх зүйн харилцааны объект байж болох ба Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт “ зар сурталчилгаа” гэж **иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил,үйлчилгээ, төсөл, үйл ажиллагааны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг**

ойлгоно” хэмээн заажээ. Нэгэнт зар сурталчилгаа нь мэдээлэл юм бол иргэний эрх зүйн харилцааны объект болох бөгөөд тухайн харилцаанд оролцогч захиалагч, бүтээгч, түгээгч, зар сурталчилгааг хүлээн авагч гээд бүхий л субъектүүд иргэний эрх зүйн харилцааны объект мөн юм. Иймд зар сурталчилгааны эрх зүйн харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар нарийвчлан зохицуулахаас гадна иргэний эрх зүйн харилцааны суурь зарчим, ерөнхий зохицуулалтын хүрээнд хамаарагддаг гэж ойлгож болно.

Зар сурталчилгааны өнөөгийн эрх зүйн зохицуулалт, иргэний эрх зүйн үүднээс түүний гэм хорын асуудлыг хөндөж гаргаж ирэхийн өмнө уг ойлголт, нэр томъёог хэрхэн тайлбарласан байдаг вэ? Гэдгийг судлаж үзэх нь зүйтэй болов уу?

Зар сурталчилгаа гэсэн нэр томъёог хэл зүйн талаас нь тайлбарласныг үзвэл “Зар-олонд зарлан нийтлэх үг буюу мэдээ¹⁰”, “сурталчилгаа- сурталчлах, сурталдахын тулд нэг үгийг байн байн сургаж ятгах, ухуулах, сэнхрүүлэх ¹¹” гэсэн утгыг тус тус илэрхийлэх аж.

Мөн Улсын Дээд шүүхээс “Зар сурталчилгаа ” гэсэн нэр томъёог дараахь байдлаар тайлбарласан байна . Үүнд :

1. “Архидан согтуурахтай тэмцэх тухай ” хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай ” дээд шүүхийн тогтоолын 4 дүгээр зүйлд “Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасан “Согтууруулах ундаа худалдах ,борлуулах , хэрэглэх талаар хэвлэл , мэдээллийн хэрэгслээр сурталчилгаахихийг хориглоно ” гэснийг бүх төрлийн сонин , сэтгүүл, радио , телевизээр болон зурагт ухуулах хуудсаар энэ хуульд нэр заагдсан согтууруулахундааг худалдан авах , хэрэглэхийг уриалсан , ухуулсан зар сурталчилгаа , рекламыг хамааруулан ойлгоно .”
2. Банкны болон банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарим зүйл , заалт , хэсгийг тайлбарлах тухай ” дээд шүүхийн тогтоолын 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3-т заасан “өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаахих , мэдээлэл өгөх” гэдэгт хууль тогтоомж , Монголбанкнаас тогтоосон журмын дагуу гаргавал зохих тайлан , тэнцэл болон бусад мэдээ , түүнчлэн мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа , түүний дотор хадгаламж ,зээлийн хүү, зээлийн чанар зэрэг асуудлаар бодит байдалд нийцэхгүй сурталчилгаа , мэдээллийг холбогдох байгууллагад өгөх, олон нийтэд тараахыг хамруулан ойлгоно .”
3. Мөн зүйлийн 12.1.2-т заасан “өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх , мэдээлэл өгөх” гэдэг нь хууль тогтоомжийн дагуу гаргавал зохих тайлан , тэнцэл болон бусад мэдээ , түүнчлэн мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.-д заасан үйл ажиллагааны талаар буюу байгууллагынхаа орлого , санхүүгийн байдал ,зээлийн хүү, зээлийн чанар зэрэг асуудлаар бодит байдалд нийцэхгүй сурталчилгаа , мэдээллийг холбогдох байгууллагад өгөх, олон нийтэд тараахыг ойлгоно .
4. Төв банк /Монголбанк /-ны тухай хууль , Банкны тухай хуулийн зарим зүйл , хэсэг , заалтыг тайлбарлах тухай ” дээд шүүхийн тогтоолын 2 дугаар зүйлд “Банкны тухай хуулийн зарим зүйл , хэсэг , заалтыг дор дурдсанаар тайлбарлахдаа ... Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтын “өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх , мэдээлэл өгөх” гэдгийг хууль тогтоомж , Монголбанкнаас тогтоосон журмын

¹⁰ Я.Цэвэл “Монгол хэлний тайлбар толь”УБ.,1966 он 267 дахь тал

¹¹Я.Цэвэл “Монгол хэлний тайлбар толь”УБ.,1966 он 491 дэх тал

дагуу гаргавал зохих тайлан , тэнцэл болон бусад мэдээ , түүнчлэн мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа , түүний дотор хадгаламж , зээлийн хүү, зээлийн чанартай холбогдсон асуудлаар буруу ташаа сурталчилгаа , мэдээллийг холбогдох байгууллагад өгөх, олон нийтэд тараахыг хамруулан ойлгоно гэжээ .

5. Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйл үүдийн зарим заалтыг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 40 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Мөн зүйл , хэсэгт заасан “...хэвлэл мэдээллийн хэрэгсэл ...” гэдгийг Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д зааснаар ойлгоно ” гэжээ . Мөн Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлийг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 51 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Мөн зүйл , хэсэгт заасан “...нийтэд тараах ...” гэж Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан хэвлэлмэдээллийн хэрэгслээр мэдээллийг олон нийтэд түгээхийг хэлнэ ” гэж тус тус тодорхойлсон байна .”

Эдгээрээс үзвэл Зар сурталчилгааны харилцааны эрх зүйн зохицуулалт дахь нэр томъёо нэг мөр болоогүй, зөрүүтэй , салаа утгыг илэрхийлсэн дутагдалтай тал байна . Эдгээрээс хамгийн чухал нь буюу тухайн харилцааны зохицуулалтын үндсэн зүйл болсон зар сурталчилгааны хувьд “зар ”, “зар мэдээ ”, “зарлал ”, “зар сурталчилгаа ”, “сурталчилгаа”, “реклам ” гэх мэт олон нэр томъёо байгаа бөгөөд эдгээрийг хууль бүрт өөр өөрөөр хэрэглэсэн байгаа нь ажиглагдсан.

Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.4 дэх хэсэгт “Тодорхой бус этгээдүүдэд хандсан хүсэл зоригийн илэрхийллэлд гэрээ байгуулах санал болохыг шууд заагаагүй бол түүнийг санал гаргах дуудлага гэнэ” гэжээ. Нэгэнт зар сурталчилгаа нь олон нийтэд чиглэсэн өөрөөр хэлбэл тодорхой бус этгээдүүдэд чиглэсэн мэдээлэл байдаг тул түүнийг гэрээ байгуулах санал гаргах дуудлага гэж үзэх үндэстэй байна. Иймд тухайн зар сурталчилгааны захиалагч гэрээ байгуулах саналын дуудлага гаргаж байгаа бөгөөд тухайн зарыг хүлээн авсан этгээд гэрээ байгуулах санал гаргах эсэхээ шийдэх ёстой.

Гэм хор гэдэг нь тодорхой этгээдийн эрх зөрчигдсөнөөс түүнд бий болсон эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус сөрөг үр дагавар юм. Үүнд эд хөрөнгө устгасан, иргэний эрүүл мэндэд гэмтэл учруулснаас эмчилгээний зардал гарсан, цалин дутуу авсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас олох ёстой байсан орлого алдагдсан, зарлага гарсан, биеийн болон сэтгэл санааны шаналал зэрэг орно. ¹² Иргэний хуулийн дагуу гэм хор учруулсан нь иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл ¹³ болох ба иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид учруулсан хохирлыг арилгуулах замаар харилцаанд оролцогчдын эрхийг хамгаалдаг. ¹⁴ Мөн түүнчлэн Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.3 дахь хэсэгт “ Гэм хорыг учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд гэм хор учруулсан этгээд төдийгүй, түүнийг уруу татсан, дэмжин тусалсан, түүнчлэн гэр хор учруулсны үр дүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээнэ” гэж заасан.

Үүнээс харахад үндэслэлтэй гэж үзвэл зар сурталчилгааг захиалагч, бүтээгч, түгээгчийг зар сурталчилгаанаас үүдэлтэй гэм хорыг учруулахад хамтран оролцсон гэж үзэж нэгэн адил хариуцлага хүлээлгэж болохрр байна. Иймд иргэд болон иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага, өмгөөлөгчид гэм хор учирсан тодорхой

¹² Т.Мөнхжаргал, Иргэний эрх зүй тусгай анги/тусгай анги/УБ.,1997 .,48 дахь тал

¹³ Иргэний хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь хэсэг

¹⁴ Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.4 дэх хэсэг

хэрэг дээр зөвхөн захиалагч буюу худалдагч, үйлчилгээ үзүүлэгчийг бус тэрхүү бүтээгдэхүүн үйлчилгээний зар сурталчилгааг үнэн бодит бус бүтээсэн түгээсэн хэвлэл мэдээллийн байгууллага, зар суриалчилгаа бүтээгч хуулийн этгээдүүдийг хамтран хариуцлагад татах нь зөвхөн тухайн иргэний эрхийг хамгаалахаас гадна хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хэвлэл мэдээллийн байгууллага, бизнесийн бусад байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх ач холбогдолтой байна.

Зар сурталчилгааны улмаас үүсэх гэм хорын тогтооход хялбар болон гэм хор учирсан субъектээр нь доорх байдлаар ангилж болох юм. Үүнд:

- Тогтооход хялбар буюу хувь этгээдэд учирсан гэм хор
- Тогтооход хялбар бус нийгэмд учирсан гэм хор

Тогтооход хялбар буюу хувь этгээдэд учирсан гэм хор гэдэгт эрүүл мэндээрээ хохирох, эд хөрөнгө нь утсан, гэмтсэн, сэтгэл ханамжгүй байдал үүссэн, бизнесийн нэр хүндээ алдах, олох байсан ашиг, орлогоо алдах зэрэг гэм хор хамаарах бол харин тогтооход хялбар бус нийгэмд учирч буй гэм хор гэдэгт буруу ташаа мэдээлэл цацах замаар төөрөгдөл бий болгох, нийгэмд муу зуршил бий болгох, буруу үлгэр, жишээ үзүүлэх замаар буруу сэдэл төрүүлэх, хүүхдийн хүмүүжилд муугаар нөлөөлөх зэрэг хамаарна.

Сүүлийн үед эм болон усний будаг, барилгын материал, хүнсний бүтээгдэхүүнээс хүмүүс их хордож байгаа боловч эмч болон үйлчлүүлэгчид тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэх болсон сэдлийг хаанаас авсанд ач холбогдол өгдөггүй учир үйлчлүүлэгч бүрийг гадуур зарласан зар сурталчилгаанд итгээд эрүүл мэнд, гоо сайхнаараа хохирсон гэж дүгнэх боломжгүй боловч эм болон гоо сайхны бүтээгдэхүүний хувьд хэвлэл мэдээллийн хэргслээр нийтэлж олон нийтэд танил болсон бүтээгдэхүүнийг сонгох магадлал өндөр байдаг байна.

Зар сурталчилгаа нь хэрэглэгчийн тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгон хэрэглэх сэдлийг бий болгодог мөртлөө тэрхүү сонголтыг хийх болсон хүлээгдсэн үр дүнг бий болгодоггүй буюу үнэн бодитой биш зарын улмаас иргэд хохирсоор байна.

Харин иргэдэд Зар сурталчилгааны хуулийн талаархи мэдээлэл өгөх, буруутай этгээдийг зөв олж тогтоон хуульд заасан хариуцлага хүлээлгүүлэхээр зохих байгууллагад хандуулдаг болгоход чиглэсэн шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зар сурталчилгааны харилцаан үндсэн оролцогчид нь зар сурталчилгаа захиалагч, зар сурталчилгааг хүлээн авагч, түгээгч гэсэн талууд оролцох ба зар сурталчилгаа захиалагчид нь өөрсдийн ажил үйлчлигээ, бүтээгдэхүүний боломжит хэрэглэгчид болох зар сурталчилгаа хүлээн авагчдад хамгийн үр өгөөжтэй арга хэлбэрээр хүргэхийг эрхэм зорилгоо болгодог бол зар сурталчилгаа хүлээн авагчид буюу хэрэглэгчид тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээс өөрт хэрэгтэй мэдээллийг олж авах зорилготой байх бөгөөд түүнийхээ төлбөрийг тухайн зар сурталчилгааг хүлээн авснаараа төлдөг. Харин хэвлэл мэдээллийн байгууллага энэ хоёр талын хүсэл зоригийг тэнцвэржүүлэх замаар өөрийн орлогын эх үүсвэрийг бий болгох зорилготой байдаг. Гэтэл хэвлэл мэдээллийн байгууллага тэрхүү тэнцвэртэй байдлыг бий болгож чадаагүйн улмаас зах зээлд илүүдэл эсвэл дутагдал үүсэх, эсвэл нийгэмд зүй бус, гаж хиймэл хэрэгцээг үүсгэх, зуршил бий болгох зэрэг сөрөг үр дагаварыг бий болгож байна.

Тиймээс зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, эдийн засгийн болон үндэсний соёл, зан заншил, байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол, сэтгэлзүй гэх мэт нийгмийн хүчин зүйлүүдэд нөлөөлдөг учраас зар сурталчилгааны агуулга, хэлбэр, хугацаа,

хэрэглэгчдийн төрлөөр хязгаарлалт, хориг тогтоох замаар төрөөс зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай юм.¹⁵

Тухайлбал: Зар сурталчилгааны хууль дотроо болон бусад хуультай давхардсан, зөрчилдөөн их, зар сурталчилгааны нэр томъёо хуулиудад өөрөөр тусгагдсан, зар сурталчилгааны хяналт хангалтгүй, хяналт тавих албан тушаалтаны тоо бага, байгууллага хоорондын уялдаа холбоо сул зэргээс хамаарч түүний эрх зүйн зохицуулалтыг улам бүр боловсронгуй болгох шаардлагатай байгаа тул дараахь саналыг дэвшүүлж байна.

1. “Зар сурталчилгаа” гэсэн ойлголтыг нэг мөр болгох үүднээс Улсын дээд шүүхээс тайлбар гаргуулах

2. “Зар сурталчилгааны бодит үнэнэийг зарлуулсан байгууллага, хувь хүн бүрэн хариуцна” гэдэг нь хууль бус гэдгийг нийтэд мэдээлэх

3. Зар сурталчилгаанд тавигдах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах зэрэг болно.

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ГЭМТ ХЭРЭГ БА УЛИРАЛ

А.Амарсайхан

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн ахлах багш,
цагдаагийн дэд хурандаа

Оршил

Монгол орны газар нутаг гадаад далай тэнгисээс ихээхэн алслагдсан, Евразийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дунджаар километр хагас илүү өндөр өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай. Монгол орны уур амьсгалын гол онцлог бол жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй. Эдгээр улирлуудад гэмт хэргийн гаралт хэрхэн хувирч өөрчлөгддөг болонгэмт хэргийн шалтгаан нөхцөлийг зөв тодорхойлсноор уг нийгмийн үзэгдлийн мөн чанарыг илэрүүлэх, түүнийг арилгах арга замыг олоход чухал ач холбогдолтой учир судалгаа, дүгнэлт хийж мөн гэмт хэргийн гаралтыг багасгах зорилгоор саналаа дэвшүүлэхийг зорилоо. Энэхүү судалгааны ажил нь гэмт хэргийн гаралтыг улирлын байдлаар авч үзсэнээрээ онцлогтой юм.

Түлхүүр үгс

Улирал, гэмт хэрэг, статистик, хүүхэд, согтууруулах ундаа

“Улирал ба гэмт хэрэг” судалгааг статистикийн судалгааны аргыг ашиглаж судалсан бөгөөд статистик нь нийгмийн үзэгдлийг судлах нэг чухал арга мөн. Статистикийн арга нь нийгмийн тодрхой үзэгдлийг судлах тэр тусмаа гэмт явдал, гэмт хэргийг судалхад үр дүнтэй арга юм.

Статистик судалгаа нь 3 үе шатанд хуваагддаг.

1. Гэмт хэргийн гаралтыг тодорхойлсон тоон үзүүлэлтийн материалыг цуглуулах.
2. Гэмт хэргийн тоо бүртгэлийн анхны материалд судалгааны хүснэгт, маягт боловсруулах.
3. Статистик ба криминологи судалгааг хийхдээ статистик аргын үндсэн дээр эхний ээлжинд бүлэглэлт хийнэ. Бүлэглэлт нь статистик судалгааны үндсэн аргын нэг мөн. Бүлэглэлт нь гол төлөв нэг үзэгдлийг нөгөөгөөс нь тусгаарлаж


¹⁵ Хууль зүйн үндэсний хүрээлэн судалгааны тайлан 2014 он

тодорхой харуулдаг учир үзэгдлийн мөн чанарт дүгнэлт хийхэд дөхөм үзүүлдэг.

Монгол улс нь эрс тэс уур амьсгалтай, жилийн 4 улирал оршидогоороо онцлогтой. Эдгээр улирлуудад гэмт хэргийн гаралт харилцан адилгүй хэлбэлзэлтэйгээр үйлдэгдэж бүртгэгдсээр байна. Гагцхүү ямар учир шалтгааны улмаас гэмт хэргийн гаралт улиралын байдлаар өөр өөр байгааг олж судлах нь цаашдаа гэмт хэргийн гаралтыг багасгахын тулд улиралын байдал тухай бүрт тохирсон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үйл ажиллагааг боловсруулахад дөхөм болох юм.


Энэхүү судалгааг хийхдээ Монгол улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоон мэдээллийг боловсруулж улиралын байдлаар буюу хавар(1-р улирал 1-3 сар), зун(2-р улирал 4-6 сар), намар(3-р улирал 7-9 сар), өвөл(4-р улирал 10-12 сар)-уудад хувааж гэмт хэргийн гаралтын ялгааг авч үзсэн болно.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо (2017 он)¹⁶



Нийслэл Улаанбаатар хотын хүн амын нягтаршил ихтэй дүүрэг болох Баянгол дүүргийн 2017 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоон статистик мэдээлэлийг авч үзвэл.

Баянгол дүүрэгт бүртгэгдсэн нийт гэмт хэрэг 2017 он



¹⁶ www.1212.mn

Үүнээс гэмт хэрэг үйлдэгдсэн байдлаар авч үзвэл:Баянгол дүүрэгт согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг хүснэгтээр авч үзвэл:

1-р сард 74	2-р сард 31	3-р сард 42	нийт-147
4-р сард 32	5-р сард 31	6-р сард 39	нийт- 92
7-р сард 11	8-р сард 10	9-р сард 7	нийт-28
10-р сард 24	11-р сард 11	12-р сард 14	нийт-49

Б

аянгол дүүрэгт хүүхэд оролцсон гэмт хэрэг:

1-р сард -13, 2-р сард -2, 3-р сард -6нийт-21
 4-р сард -7, 5-р сард -7, 6-р сард -10нийт -24
 7-р сард -1, 8-р сард -2, 9-р сард -6нийт-9
 10-р сард -5, 11-р сард -1, 12-р сард -0нийт-6

Энэ статистик тоо баримтуудаас авч үзвэл гэмт хэргийн гаралт сэрүү орох үеэр буюу намар, өвлийн цагт харьцангуй өсөлттэй байх бөгөөд 7,8,9 сард хүмүүсийн зуны амралт дуусч хөдөө орон нутаг уруу амралтаараа явсан иргэд буцаж хотод төвлөрч мөн хичээлийн шинэ жил эхэлдэгтэй холбоотой байж болох талтай. 10,11,12 саруудад ч мөн адил бүртгэгдсэн гэмт хэргийн тоо их байгааг хүйтний эрч чангарч шунахайн сэдэлтэй орон байрны, авто машины, халаасны гэх мэт хулгайн гэмт хэргүүд ихэсдэг бөгөөд ялангуяа гэр хороололд болон хүн ам ихтэй газруудад ихээр үйлдэгддэг.

Мөн энэхүү судалгаанаас баяр ёслолууд ихээр болдог улиралууд буюу 1,2, 3 дугаар саруудад согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо өсөлттэй харагдаж байна.

Монгол түмний уламжилалт баяр болох Цагаан сар мөн Эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалах өдөр болон цэргийн баяр гэх мэт олон баяр ёслолыг бүх нийтээрээ өргөн хүрээтэй тэмдэглэдгээс гадна архи дан согтуурах цаашлаад согтуугаар гэмт хэрэг үйлдэх нэгэн шалтгаан болдог гэж дүгнэж байна.

Судалгаанаас 4,5, 6 дугаар саруудад хүүхэд үйлддэг болон хүүхдийн эсрэг гэмт хэрэг ихэсдэг нь харагдаж байгаа бөгөөд хүүхэд хохирсон гэмт хэргийг ангилан авч үзвэл хүүхдийн амь нас хохирсон, бэлгийн хүчирхийлэлд өртсөн, танхайрах, хулгайлах, зам тээврийн осолд орсон зэрэг төрлүүд байна.

Манай улсын хувьд хүүхдийн гэмт хэрэг гаралтыг хүн амынхаа тоотой харьцуулахад их гэж үздэг. 2017 онд л гэхэд хүүхэд хохирсон 1757 гэмт хэрэг бүртгэгдсэн. Өөрөөр хэлбэл нэг ерөнхий боловсролын сургуулийг дунджаар 1500-2500 хүүхэдтэй гэж бодоход бүтэн нэг сургуулийн хүүхэд тэр чигээрээ хохирсон гэсэн үг.¹⁷

Энэхүү “Улирал ба гэмт хэрэг” сэдвийн хүрээнд судалгааны ажил хийсний үр дүнд дараах дүгнэлтэнд хүрч байна.

Монгол улсын хувьд согтуурлын улмаас олон тооны ноцтой гэмт хэрэг үйлдэгдэн гарсаар байна. Тухайлбал бусдын амь насыг хохироох, хүний биед хүнд болон хүндэвтэр гэмтэл учруулах, хүчиндэх, дээрэмдэх зэрэг хүч хэргэлсэн ноцтой гэмт хэргүүд үйлдэгдэж байна. Архидалт, согтуурал нь хэдийгээр өвлөгдөн ирсэн түүхэн үзэгдэл боловч үүнтэй тэмцэл хийхгүйгээр аяндаа устаж үгүй болохгүй юм.

Үүнээс гадна Монгол улсын тулгамдсан гол асуудлуудын нэг бол яах аргагүй хүүхдийн эсрэг болон хүүхэд холбогдон гэмт хэрэг юм. Хүүхэд гэмт хэрэгт холбогдох олон шалтгаан

¹⁷Цагдаагийн ерөнхий газар “Хүүхдээ хамгаалъя” аян тайлан. УБ 2018 он

бий. Хамгийн гол нь ажилгүйдлээс үүдэлтэй ядуурал, архидалт гэр бүлийн уур амьсгал, хүүхдийн хүмүүжилд их нөлөөлж байна.

Өнөөдөр гэмт хэрэг үйлдэж буй хүүхдүүдийн 90 орчим хувийнх нь гэр бүл ямар нэг асуудалтай нь тогтоогдсон. Хүмүүс ажлаа сайн хийж, мөнгө олоод үр хүүхдээ хоол ундтай байлгах ёстой гэж зүтгэх зууртаа амьдралынхаа жинхэнэ зорилго болох үр хүүхдээ сайн хүн болгож төлөвшүүлэх, зөв хүмүүжүүлэхээ орхигдуулаад байдаг.¹⁸

Өмсөх хувцастай, идэх хоолтой, юугаар ч дутаахгүй байлгана гэдэг бол өрөөсгөл ойлголт. Хүүхдүүдэд эцэг эхтэйгээ ярьмаар, зөвлөмөөр, асуумаар олон зүйл байгаа. Гэтэл тэднийг сонсохгүй, анхаарал хандуулахгүй байхаар хүүхэд гэмт хэрэгт санаатай, санамсаргүй янз бүрийн байдлаар холбогдож байна. Ихэнх тохиолдолд хүүхэд гэмт хэрэг үйлдэхдээ эцсийн хор уршгийг нь ухамсарладаггүй. Ер нь гэр бүлийн хайр халамж дутуугаас болж, нөгөө талаас эцэг эхийн хараа, хяналт муутайгаас үүдэж бага насны хүүхэд бусдын халдлагад өртөж байна.

Энэ бүх гэмт явдлуудыг улиралын байдлаар судалж үзсэний гол үр дүн нь гэмт хэргийн төрөл, үйлдэгдсэн байдал, арга зэргийг улирлаар нь нарийн судалж тогтоон тухайн улиралд ихээр үйлдэгддэг гэмт хэрэг гарахаас сэргийлэх урьдчилсан арга хэмжээг авах төлөвлөгөөг боловсруулан үйл ажиллагаа явуулснаар гэмт хэргийн гаралтыг багасгах давуу талтай юм гэж дүгнэж байна.

Энэ бүх гэмт явдлуудыг улирлын байдлаар судалж авч үзсэний эцэст дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Тухайн улиралд ихээр үйлдэгддэг гэмт хэргийг нарийн тогтоож түүний эсрэг чиглэсэн арга хэмжээг авах.
2. Баяр ёслолууд ихээр болдог улирлуудад архидан согтууралтын эсрэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өргөнөөр явуулах мөн архи, согтууруулах ундаа зарах зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих.
3. Олон нийт болон Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулж архидан согтуурахын хор уршигийг тайлбарлан сурталчилах.
4. Цагдаагийн байгууллага болон эцэг, эхчүүдийн хамтын ажиллагааг сайжруулах. Өөрөөр хэлбэл ерөнхий боловсролын сургуулиудад Цагдаагийн байгууллагаас эцэг, эхчүүдэд сургалт зохион байгуулж хүүхдүүддээ анхаарал халамж тавих нь хүүхдээ гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх хамгийн гол арга болохыг тайлбарлах.

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРЬЦУУЛАЛТ

Д.Цэрэнлхам

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн багш-
дадлагажигч, цагдаагийн ахлагч

Товч агуулга

Шүүхийн хараат бус байдал нь шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдал гэсэн 2 талтай. Шүүх эрх мэдэл интитуцийн хувьд хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус байх хамгаалалт, нөхцө ямар хэмжээнд бүрдсэн, шүүхийн эдийн засгийн бие даасан байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, механизм доголтой эсэх, шүүхийн захиргааны бие даасан байгууллага төлөвшихөд эрх үүргийн хуваарилалт зохих ёсоор бүрэлдсэн эсэх зэрэг эдгээр асуудал нь хараат бус шүүхийн анхдагч ойлголт шүүхийн бие даасан зарчмын тухай асуудалд хамрагдах тул миний энэхүү судалгааны ажил уг сэдвийн хүрээнд өрнөх юм.

¹⁸ www.police.gov.mn

Түлхүүр үгс

Шүүх, шүүх эрх мэдэл, шүүхийн бие даасан байдал, зарчим, Үндсэн хууль.

Үндсэн хэсэг: Шүүхийн бие даасан байдлын зарчим нь аливаа ардчилсан Үндсэн хуулиудад ерөнхий болон нарийвчилсан байдлаар тусгагдсан байдаг салшгүй хэсэг юм.

Шүүх эрх мэдлийг хамгаалсан Үндсэн хуулийн гол заалтууд шүүхийн хараат бус байдлын Үндсэн хуулийн дэд бүтцийг тогтоодог. Эдгээрт интитуцийн бүтцийг баталгаажуулсан, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс шүүх эрх мэдэлд нөлөөлөхгүй байх заалтууд ордог¹⁹. Шүүх бусад эрх мэдлээс бүтцийн хувьд бие даасан байх зарчмыг дэлхийн улсууд Үндсэн хуульдаа хэрхэн бэхжүүлсэн, бүтцийн бие даасан байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэх механизмыг Үндсэн хуулийн түвшинд хэрхэн сонгосон, хамгаалсан талаар авч үзнэ ээ.

Шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн баталгаа

1. **Америкийн нэгдсэн улс:** Шүүхийг бусадэрх мэдэлтэй харилцан хяналт, тэнцвэртэй засаглалын нэг салаа байх ёстой гэсэн Монтескьегийн онол АНУ-ын Үндсэн хуулинд анх тусгалаа олсон. Тус улсад шүүх эрх мэдэл нь шүүхийн захиргааны асуудлаар хууль тогтоох эрх мэдэлтэй ихэнхдээ шууд харилцдаг. Өөрөөр хэлбэл гүйцэтгэх эрх мэдлээр дамждаггүй гэсэн үг. Үндсэн хуульд заасны дагуу хууль тогтоогч нь шүүх байгуулах, шүүхийн харъяаллыг тодорхойлох, мөн тангарагтны шүүгчийг сонгох, шүүхийн хураамжийн зэрэг шүүхийн үйл ажиллагааны асуудлыг зааварчлах, түүнчлэн шүүхийн төсвийг тогтоох эрхтэй. Хууль тогтоогч нь шүүхийн процессын хуулийг батлах бүрэн эрхийг мөн эдэлдэг. Түүнчлэн хууль тогтоогч нь шүүгчид тавигдах шаардлагыг тодорхойлж болно. Шүүгчийн албан тушаалаас нь огцруулж болно. Эдгээр хууль тогтоогчийн үүргүүд нь хууль тогтоогчийн хяналтыг шүүх эрх мэдэлд бий болгодог. Тухайлбал: Шүүх татварын мөнгийг хэрхэн зарцуулж байгаа, иргэдэд хэрхэн үйлчилж байгаад хууль тогтоогчийн өмнө хариуцлагатай байх ёстой.

АНУ-ын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд “Нэгдсэн Улсын шүүх засаглалыг нэг Дээд шүүх болон Конгресоос шаардлагын дагуу тухай бүр байгуулах доод шатны шүүхүүд хэрэгжүүлнэ. Дээд болон доод шатны шүүхийн шүүгчид зан төлөвийн хувьд үлгэр жишээ ч байж гэмээн албан тушаалдаа байна. Тэд тогтоосон хугацаанд алба хашсанахаа төлөө нөхөн төлбөр авах бөгөөд албан тушаалдаа байх хугацаанд нь түүнийг бууруулж болохгүй”²⁰ хэмээн шүүхийн хараат бус байдлыг хангах үндсэн хамгаалалтыг хуульчилсан.

Дээрхээс үзвэл АНУ-ын Үндсэн хуулинд дахь эрх мэдэл хуваарилалтын дагуу бол хууль тогтоогч нь шүүхийн эрх зүйг бүтээх Үндсэн хуулийн бүрэн эрхтэй байна. Харин гүйцэтгэх эрх мэдэл нь шүүхийн эрх зүйн хамгаалалтад нөлөөлөрүйц бүрэн эрхийг Үндсэн хуулийн дагуу эдэлдэггүй гэж үзэж болохоор байна. Мөн тус улсын Үндсэн хуульд шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх Үндсэн хуулийн баталгааг тусгаж өгчээ. Мөн хууль тогтоогчийг шүүгчийн цалингуу бууруулах, шүүгчийн албан тушаалаас нь үндэслэлгүй огцруулахаас сэргийлсэн хязгаарлалтыг тогтоожээ. Харин шүүхийн захиргааг шүүх өөрөө хэрэгжүүлэх, шүүхийн төсвийн бие даасан байдлын баталгааг Үндсэн хуулиар бэхжүүлээгүй байна. Тус улсад шүүх өөрийн захиргааны чиг үүргээ өөрөө эрхлэх үзэл санаа 1939 оноос буюу Үндсэн хууль батлагдсанаас 150 гаруй жилийн дараа хэрэгжиж эхэлсэн юм.

2. **Холбооны Бүгд найрамдах Герман улс:** Германы төрийн эрх мэдэл хуваарилалт нь хаирлцан хяналт, тэнцвэртэй хийгдсэн. Засаглалын салаануудыг институцийн хувьд тусгаарлахаас илүү шүүхийг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс чиг үүргийн хуульд тусгаарласан гэж үздэг ажээ. Энэ хандлагын дагуу шүүхийн захиргааг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх эрх мэдэл одоо хүртэл голлох үүрэг гүйцэтгэдэг. Учир нь шүүхийн захиргааны чиг үүргийг шүүн таслах гэхээсээ илүү гүйцэтгэх чиг үүрэг хэмээн үздэг.

Шүүхийн бие даасан байдлын зарчим нь Германы Үндсэн хуулийн үндсэн зарчмуудын нэг юм. Шүүхийн зохион байгуулалт, статус нь Германы Үндсэн хуулийн 92-104 дүгээр зүйлд

¹⁹ Shimon Shetreet and Christopher Forsyth (eds), The Culture of Judicial Independence: Conceptual Foundations and Practical Challenges, Leiden:MartinusNijhoff, 2012, p20

²⁰Америкийн нэгдсэн улсын Үндсэн хууль, орчуулагч Д.Цолмон, Ч.Лхагважав, 41-р тал.

тусгагдсан бөгөөд 97.1-д “Шүүгч нь хараат бус байж гагцхүү хуульд захирагдана” гэж зааснаар шүүхийн хараат бус байдлын зарчмыг бэхжүүлсэн. 97.2-т “орон тооны болон байнгын шүтгээр томилогдсон бол түүний хүсэл сонирхлынх нь эсрэг гагцхүү шүүхийн шийдвэрээр тэгэхдээ зөвхөн хуульд заасан үндэслэл болон хэлбэрээр бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө албан тушаалаас нь чөлөөлөх эсхүл бүрмөсөн буюу түр хугацаагаар түдгэлзүүлэх эсхүл өөр албан тушаалд шилжүүлэх буюу тэтгэвэрт гаргаж болно. Бүх насаараа томилогдсон шүүгчийг тэтгэвэрт гаргаж болох насны хязгаарыг хуулиар тогтоож болно. Шүүхийн бүтэц, эсхүл харьяалах тойрог өөрчлөгдөхөд шүүгчийг шүүхийн өөр байгууллагад шилжүүлж буюу ажлаас нь чөлөөлж болно, гэхдээ аль ч тохиолдолд цалин хөлсийг нь бүрэн хэмжээгээр олгоно” хэмээн зохицуулжээ.

Хууль тогтоох эрх мэдлээс бие даасан байдал. Хууль тогтоох эрх мэдэлтэй харьцах шүүхийн бие даасан байдал Үндсэн хуулийн түвшинд баталгаажсан. Гэхдээ шүүх нь хуульд захирагдан ажиллах ёстой. Германы Үндсэн хуулийн 97.1-д зааснаар шүүгч нь хуульд захирагдах бөгөөд парламент хуулийг өөрчлөх эрх мэдэлтэй. Харин парламент тодорхой асуудлыг зохицуулсан хууль тогтоомж баталж тодорхой нэг хэргийг шүүхээр шийдвэрлэхэд нөлөөлж болохгүй. Мөн хууль тогтоогч шүүгчээс аливаа хэргийг тодорхой хэлбэрээр шийдвэрлэхийг шаардсан шийдвэр гаргаж болохгүй.

Гүйцэтгэх эрх мэдлээс бие даасан байдал. Германд гүйцэтгэх эрх мэдэл шүүхийн захиргааг хэрэгжүүлдэг тул шүүхийн шүүн таслах үндсэн чиг үүрэг болон захиргааны чиг үүргийг ялга үздэг байна. Шүүхийн үндсэн чиг үүрэг болох шүүн таслах ажиллагаанд гүйцэтгэх эрх мэдлээс оролцохыг хориглодог.

Тус улсын Үндсэн хуулийн дагуу шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль тогтоомжийг парламент батлах эрхтэй, гэхдээ парламент нь тодорхой асуудалд зориулж хууль батлах замаар шүүхийн бие даасан байдалд халдахыг Үндсэн хуулиар хоригложээ. Гүйцэтгэх эрх мэдэл нь шүүн таслах чиг үүрэгт нөлөөлөхийг Үндсэн хуулиар хориглосон боловч шүүхийн захиргааны удирдлагад оролцох боломжтой нь энэ улсын нэг онцлог гэж үзэхээр байна.

3. **Итали Улс:**²¹ Италийн 1948 оны Үндсэн хуулийн 102 дугаар зүйлд “Шүүн таслах үйл ажиллагааг шүүхийн тухай хуульд заасны дагуу шүүгч хэрэгжүүлнэ. Тусгай шүүгчийн орон тоог бий болгож болохгүй” хэмээн шүүхийн бие даасан байдлын суурь зарчмыг бэхжүүлсэн. Мөн 104 дүгээр зүйлд “Шүүх нь төрийн бусад эрх мэдлээс бие даасан байна” гэж хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс шүүх автономи байх суурь зарчмыг бэхжүүлж, цаашлаад 105 дугаар зүйлд “Магистратын дээд зөвлөл нь шүүгчийг томилох, шилжүүлэх, дэвшүүлэх, сахилгын шийтгэл хүлээлгэх асуудлыг хуульд зааснаар шийдвэрлэх бүрэн эрхтэй”, 110 дугаар зүйлд “Хууль зүйн сайд нь Магистратын дээд зөвлөлийн бүрэн эрхийг хязгаарлахгүйгээр шүүхтэй холбоотой үйлчилгээ, зохион байгуулалтын үүргийг гүйцэтгэнэ” хэмээн шүүхийн захиргааны удирдах байгууллагыг бусад эрх мэдлээс тусад нь байгуулж, түүний үйл ажиллагаанд Хууль зүйн яамнаас оролцох нөлөөллийг хязгаарлаж өгсөн нь онцлог байна.

Дээрхээс үзвэл Итали улсын Үндсэн хуульд шүүх бусад эрх мэдлээс институцийн хувьд бие даасан байх суурь зарчмыг бэхжүүлээд зогсохгүй энэ зарчмыг хэрэгжүүлэх бүтэц болох магистратын дээд зөвлөлийг үндсэн хуулиар байгуулж, түүний эрх хэмжээг тодорхойлжээ. Мөн гүйцэтгэх эрх мэдлээс Магистратын дээд зөвлөлийн үндсэн чиг үүрэг нөлөөлөхийг хориглосон байна. Үүгээрээ тус улс нь шүүхийн өөрийн захиргааг Үндсэн хуулийн түвшинд сайтар бэхжүүлсэн байна.

4. **Оросын холбооны Улс:**²² 1993 оны Үндсэн хуулийн 7-р бүлгийн 118-119 дүгээр зүйлд шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн үндсийг тодорхойлсон. Тус улсын Үндсэн хуулийн 118.1-д шүүх эрх мэдлийг зөвхөн шүүх хэрэгжүүлнэ гээд 118.3-т тусгай шүүх байгуулахыг хориглосон. Үндсэн хуулийн 120.2-т “Шүүх төрийн бусад байгууллагыг хууль зөрчсөн гэж

²¹http://www.senato.it/documenti/repository/istituzione/costituzione_inglese.pdf

²²<http://www.constitution.ru/en/10003000-08.htm>

шийдвэрлэвэл тэрхүү байгууллага нь шийдвэрээ хуульд нийцүүлэх арга хэмжээ авна” гэж заасан нь шүүх бусад эрх мэдэлд хяналт тавих Үндсэн хуулийн баталгааг бүрдүүлжээ.

ОХУ-ын Үндсэн хуулийн 124 дүгээр зүйлд шүүх нь зөвхөн холбооны төсвөөс санхүүжих бөгөөд бие даасан, бүрэн төгс шүүхийн захиргаа нь холбооны хуульд заасан шаардлагад нийцсэн байна хэмээсэн нь шүүхийн эдийн засгийн болон захиргааны бие даасан байдлыг зохицуулсан нь онцлогтой байна.

Дүгнэлт: харьцуулсан судалгаанд хамрагдсан улсуудад шүүхийн бие даасан байдлын зарчмыг Үндсэн хуулиндаа тусгайлан оруулаад зогсохгүй шүүхийн өөрийн захиргааны Үндсэн хуулийн үндэс, бие даасан байдал, эрх хэмжээг тогтоож бусад эрх мэдлээс нөлөөлөх нөлөөллийг хязгаарласан зохицуулалт Үндсэн хуулиндаа тусгаж өгсөн байна.

Шүүхийн төсөв, санхүүгийн бие даасан байдал.

Шүүхийн эдийн засгийн бие даасан байдлыг хангахын тулд зарим улсад шүүхийн төсвийг улсы төсвийн тусгай бүрэлдэхүүн болгож түүний хэмжээг тодорхойлох хандлага байна. Энэ нь шүүхийг бусад эрх мэдлээс институцийн хувьд бие даасан байлгах, шүүх чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгийг үндсэн хуулийн түвшинд бэхжүүлэх үндсэн зорилготой гэж үзэж болно. Шүүхийн төсвийн хэмжээг Үндсэн хуулиар тогтоох хандлага Латин Америкийн зарим улсад хүчтэй хөгжсөнийг дараах байдлаар тоймлон хүргэж байна.

Хүснэгт№1.Шүүхийн төсвийн хэмжээг тодорхойлсон Үндсэн хуулийн зохицуулалт

Д/д	Улс, Үндсэн хууль	Зүйл	Агуулга
1	Боливи, 1967	116	Шүүх эрх мэдлийн төсөв улсын төсвийн 3 хувийг эзэлнэ.
2	Коста Рика 1949	124	Шүүх эрх мэдлийн төсөв улсын төсвийн 6 хувийг эзэлнэ.
3	Эквадор 1978	168	Шүүх эрх мэдлийн төсөв улсын төсвийн 2,5 хувийг эзлэнэ
4	Эл Сальвадор 1983	172	Улсын төсвийн тухайн үеийн орлогын 6 хувийг шүүхэд хуваарилна.
5	Гватемал 1985	213	Улсын төсвийн энгийн орлогын 2-оос доошгүй хувийг шүүхэд хуваарилна
6	Гондурас 1982	306	Улсын цэвэр орлогын төсвийн 3-аас доошгүй хувийг жил бүр шүүхэд хуваарилна.
7	Никарагуа 1986	159	Улсын нэгдсэн төсвийн 4 хувийг шүүхэд хуваарилна.
8	Парагвай 1992	156	Улсын төсвийн 3-аас доошгүй хувийг шүүхэд хуваарилна.

Шүүгчийн цалингийн Үндсэн хуулийн хамгаалалт

Шүүхийн эдийн засгийн бие даасан байдлыг бүрдүүлэгч гол цөм нь шүүгчийн цалин хангамж, түүний баталгаа юм. Зарим улсын Үндсэн хуульд шүүгчийн албан тушаалд байх хугацаанд түүний албан тушаалын цалинг бууруулахыг хориглодог. Үүний гол зорилго нь хууль тогтоогч асвэл засгийн газар цалинг шууд бус хэрэгсэл болгон шүүгчид нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх явдал юм. Шүүгчийн цалингийн баталгааг үндсэн хуулиараа тогтоосон зарим улсын зохицуулалтыг дараах хүснэгтээр авч үзье.

Хүснэгт№2 Шүүгчийн цалингийн хамгаалалт /Үндсэн хуулийн харьцуулалт/

Д/д	Улс	Зүйл	Агуулга
1	АНУ, 1787	3	Дээд болон доод шатны шүүхийн шүүгчид зан төлвийн хувьд үлгэр жишээ ч байж гэмээн албан тушаалдаа байна. Тэд тогтоосон хугацаанд алба хашсаныхаа төлөө цалин авах бөгөөд албан тушаалдаа байх хугацаанд нь цалинг нь бууруулж болохгүй.

2	Австрали, 1990	72	Холбооны шүүгчид нь парламентаас тогтоосон цалин авна, гэхдээ шүүгчийг албан тушаалдаа байх хугацаанд нь цалинг нь бууруулж болохгүй.
3	Аргентина, 1994	110	Шүүгч ёс зүйн зөрчил гаргахаас бусад тохиолдолд албан тушаалдаа байх ба албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө хуулиар тогтоосон цалин авна, шүүгчийг албан тушаалдаа байхад цалинг нь бууруулж болохгүй.
4	Энэтхэг	125, 360	Онц байдлын үед шүүгчийн цалинг бууруулж болно.
5	Канад	100	Дээд түвшний шүүгчийн цалин хөлсийг Канадын парламент тогтооно гэж заасан.

Эндээс үзэхэд зарим улс шүүгчийн цалинг бууруулахгүй байх Үндсэн хуулийн хаязгаарлалтыг хууль тогтоогчид тавьдаг нь харагдаж байна. Энэ нь шүүхийн төсвийн хэмжээний гол цөмийг эзэлдэг шүүгчийн цалингийн хэмжээг хууль тогтоогчоос хамгаалах ач холбогдолтой механизм юм.

Судалгаанд хамрагдсан улсуудад шүүх эрх мэдлийг зөвхөн шүүх хэрэгжүүлэх зарчим, шүүх нь зохион байгуулалт, захиргааны удирдлагын хувьд бусад эрх мэдлээс шүүхийн шүүн таслах болон захиргааны чиг үүрэгт Үндсэн хуульд зааснаас гадуур халдахыг хориглох зэрэг үндсэн зарчмуудыг тусгажээ. Түүнчлэн зарим улсуудад шүүхийн төсвийн хэмжээ, шүүгчийн цалингийн баталгааг тусгайлан зохицуулсан нь шүүхийн эдийн засгийн бие даасан байдлын Үндсэн хуулийн эрх зүйн түвшний ач холбогдлыг илэрхийлж байна.

Дүгнэлт

Шүүхийн бие даасан байдал гэдэг нь шүүхийн хараат бус байдлын үндэс суурь мөн. Шүүхийн хараат бус байдал нь шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгчийн хувьд шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэхэд гадны зүй бус нөлөөлөл, дарамт, оролцооноос ангижирсан байх эрх зүй, эдийн засгийн баталгаа бүрдсэн байх, шүүгч нь чин шударгаар шүүн төслөх чиг үүргийг хэрэгжүүлэх хүсэл зориг, ёс зүй бүрэлдсэн байх төдийгүй шүүх интитуцийн хувьд төрийн бусад эрх мэдлээс бие даасан байх бүтцийн болон эрх зүй, эдийн засгийн баталгаа бүрэлдсэн байхыг ойлгоно.

Шүүхийн бие даасан байдлыг бүрдүүлэгч үндэсэн элементүүд нь аливаа улсын Үндсэн хуульд суурь зарчим болж, цаашлаад шүүхийн эрх зүйд бэхжигдэх нь бие даасан байдлын эрх зүйн баталгаа болж өгдөг. Мөн аливаа улсын Үндсэн хуульд төрийн эрх мэдэл хяналт тэнцвэртэй хуваарилагдсан байх нь шүүх эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл болон улс төрийн хүчнүүдээс хамгаалах улс төрийн үндсэн баталгааг бүрдүүлдэг байна. Шүүхийн бие даасан байдлын зарчим нь дэлхийн улсуудын Үндсэн хуулиар хамгаалагдсан суурь зарчим юм.

Харьцуулсан судалгаанд хамрагдсан улсуудад шүүх эрх мэдлийг зөвхөн шүүх хэрэгжүүлэх зарчим, шүүх нь зохион байгуулалт, захиргааны удирдлагын хувьд бусад эрх мэдлээс шүүхийн шүүн таслах болон захиргааны чиг үүрэгт Үндсэн хуульд зааснаас гадуур халдахыг хориглох зэрэг үндсэн зарчмуудыг Үндсэн хуульдаа тусгажээ. Шүүхийн эдийн засгийн бие даасан байдлыг хангахын тулд зарим улсад шүүхийн төсвийг улсын төсвийн тусгай бүрэлдэхүүн болгож түүний хэмжээг тодорхойлох хандлага байна. Энэ нь шүүхийг бусад эрх мэдлээс интитуцийн хувьд бие даасан байлгах, шүүх чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгийг Үндсэн хуулийн түвшинд бэхжүүлэх үндсэн зорилготой гэж үзэж болно. Түүнчлэн зарим улсын Үндсэн хуульд шүүгчийн цалингийн баталгааг тусгайлан зохицуулсан нь шүүхийн эдийн засгийн бие даасан байдлын Үндсэн хуулийн эрх зүйн түвшний ач холбогдлыг илэрхийлж байна.

МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ИННОВАЦИ
БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Ж.Нямдулам

ХСИС-ийн Эрх зүйн нийгмийн ухааны сургуулийн
ЭЗОТ-ийн ахлах багш, хууль зүйн ухааны доктор
(Ph.D), цагдаагийн хошууч

Товч агуулга

Энэхүү илтгэл нь Монгол улсад хийгдэж байгаа уул уурхайн салбарын инноваци, эдийн засгийн үр ашиг, цааждын энэ салбарын хөгжлийн асуудлаар болон уул уурхайн салбарт хийгдэх эрх зүйн шинэтгэлийн талаар авч үзсэн болно. Үүнтэй холбоотойгоор судлаач уул уурхайн салбарт үйлдэгдэх гэмт хэргийн эрүүгийн нөхцөо байдал, түүнтэй тэмцэхэд хууль сахиулах байгууллагын инновацийн талаар судалсан болно.

Сүүлийн жилд дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд улсынхаа хөгжлийн гарц, хэтийн төлөвлөлтөө тодорхойлсон хөтөлбөр боловсруулж, инновацийг эрчимжүүлэх тал дээр анхаарал хандуулж байгаа энэ үед Монгол Улс ч улс орныхоо хөгжлийн гарц, хэтийн төлөвлөлтийг боловсруулах, бүх салбарт инновацийг хөгжүүлэх, улс орныг эдийн засгийн үр ашигтай, шинэ санаагаар хөгжүүлэх чиглэлийг баримталж байгаа өнөө үед ХСИС энэ чиглэлээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж байгаа нь сайшаалтай байна.

Инноваци гэж шинэ бүтээмж, шинэ санааг эдийн засгийн эргэлтэд оруулж, үйлдвэрлэл, үйлчилгээ, төрийн удирдлагын салбарт дэвшилтэт үр нөлөө авчрах шинэ буюу шинэчлэгдсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ технологийн процесс, мөн удирдлага, зохион байгуулалт, санхүү, эдийн засгийн болон бусад шийдлүүд инновацийн үр нөлөө юм²³. Монгол Улс 2012 онд инновацийн тухай хуулийг баталж, “инноваци” гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах цогц үйл явцыг хэлнэ гэж тодорхойлжээ.

Монгол улсын засгийн газар сүүлийн хэдэн жилд улс орны эдийн засгийн хөгжлийн гол гарцыг уул уурхайн салбарлуу голлон хандуулж, энэ салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татаж, уул уурхайн салбар эрчимтэй хөгжсөн. Харин сүүлийн 2 жилд энэ салбарыг сорьсон он жилүүд байж, зах зээлд алтны үнэ буурч, уул уурхайн компаниуд зарим нь хаагдаж, уул уурхайн томоохон төслийг хэрэгжүүлэгч Рио Тинто болон Монгол Улсын Засгийн газар хооронд татварын маргааны асуудал үүсч, ажиллагсдаа цомхотгох, уурхайг түр зогсоож, зарцуулалтаа царцаах арга хэмжээнүүд авсан нь эргээд энэ нь ирээдүйг харсан шийдэл биш юм гэдгийг инновацилаг компаниуд олж харж байна.

Өнөөдөр технологийн инновацийг уул уурхайн салбар дахь аль нэг дан ганц асуудлыг Оновчлох энгийн хэрэгсэл гэж харахаас илүүтэйгээр уул уурхайн баялаг бүтээх иж бүрэн гинжин хэлхээг Оновчлох үйл ажиллагааны технологи гэж харж байна.

Засгийн газар экспортын чиг хандлагатай үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд уул уурхайн салбарыг тус орны эдийн засгийн тэргүүлэх салбар болгон тодорхойлсон бөгөөд тодорхой хөнгөлөлтийг эдлүүлэн байгаль орчинд сөрөг нөлөө багатай тэргүүний техник, технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах зэрэг таатай нөхцөл бүрдүүлэн ажиллаж, уул уурхайн салбараас улсын эдийн засагт оруулж буй хувь нэмэр өсч 2010 онд 2’704’877.8 сая төгрөгний нэмүү өртөг үйлдвэрлэсэн нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 28.2%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 65,4 хувь, экспортын бүтээгдэхүүний 84.4 хувийг тус тус бүрдүүлж байна.

Үүнийг хуснэгт №1 харууллаа.

²³WikipediA The Free Encyclopedia. <http://en.wikipedia.org/wiki/Innovation>. Хандалт. 17.09.2014.

Узуулэлт	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Дотоодын нийт бүтээгдэхүүний	10.1%	12.7%	17,3%	18.0%	30%	27.5%	28.2%	28.2%
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний	47.3%	49.6%	64,7%	65,5%	72%	67.8%	64.3%	65.4%
Экспортын нийт бүтээгдэхүүний	56.7%	58.9%	70.8%	75,8%	67.9%	68.8%	80.7%	84.6%

Сүүлийн 10 жилд алт олборлолт 17 дахин, зэс-молибдений хүдэр олборлолт 30.4 хувь, хайлуур жоншны баяжмал үйлдвэрлэлт 14.6 хувиар тус тус өссөн байна. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ суулийн 6 жилийн дотор эрчимтэй өсч, улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нэмэгдэж байна.

Уул, уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ \сүүлийн 6 жилээр\

Хүснэгт №2.

№	Бүтээгдэхүүн	х/нэгж	2008	2009	2010	2011	2012	2013
1	Бүхэллэг жонш	мян.тн	206.7	233.4	239.4	245	219.1	344.2
2	Флотацын баяжмал	мян.тн	102.7	93.7	108.3	109.9	115.7	115.3
3	Баяжмал дахь зэс	мян.тн	130	126.3	129.7	130.2	126.8	129.8
4	Баяжмал дахь молибдени	тн	1141	1153	1403.9	1978.3	1783.6	2408.7
5	Цагаан тугалганы баяжмал /50%/	тн	22	47	-	27.5	87.5	15
6	Гянт болдын баяжмал /68%/	тн	77.1	78.2	182.2	244.5	141.9	38.6
7	Нүүрс	мян.тн	6665	7517.1	8074.1	9237.6	9691.6	13163.9
8	Алт/химийн цэврээр./	кг	18500	21900	21267	18087	15184	9803
9	Катодын зэс	тн	2376.1	2474.5	2618.4	3006.5	2586.6	2470.1
10	Төмрийн хүдэр	мян.тн	33.5	167.7	180	265.1	1387.4	1379.0
11	Цайрын баяжмал /чийгтэй/	мян.тн	-	22.8	109.9	154.7	143.6	156.5
12	Цувимал зэс	тн	-	195.5	221.2	-	-	-
13	Молибденийн исэл	тн	-	-	157.8	2664	2112.2	156.5

Монгол улс 2013 оны эхний улирлын байдлаар нийт 39 оронд бараа, бүтээгдэхуун экспортолсноос БНХАУ-д 92.1 %, Канад улсад 2.4 %, ОХУ-д 1.9 %, Судан улсад 0.7 %, Энэтхэг

улсад 0.6 %, БНСУ блон ХБНГУ-д тус бүр 0.4 %, Итали болон Их Британи улсад тус бүр 0.3 %, Вьетнам улсад 0.2 % ногдож байгаа нь экспортын 99.3 хувийг эзэлж байна. Экспортын 98.0 %-г эрдэс баялаг, унэт ба хагас унэт чулуу, унэт металл, боловсруулсан арьс шир, ангийн ус, тэдгээрээр хийсэн эдлэл зэрэг эзэлж байна²⁴.

Өнөөдөр манай улсад 10 гаруй нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явагдаж байгаа бөгөөд энэ нь ихэвчлэн анхан шатны боловсруулалт хийсэн баяжмал маягаар экспортод гарч байна.

Цаашид нөөц нь тогтоогдсон ашигт малтмалын орд газруудыг ашиглалтанд оруулахаас гадна одоо ажиллаж байгаа үйлдвэрүүд дээр технологийн шинэчлэл хийх, өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн гаргах чиглэлд анхаарах шаардлагатай юм. Үүний тулд уул, уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах, тогтвортой байдлыг хангаж өгөх, төрийн оролцоог зохистой хэмжээнд оролцуулах зэрэг нөхцөл, бололцоог бүрдүүлэх нь чухал юм.

Дэлхийн томоохон эдийн засагчид үзэхдээ: аливаа улс орон уул, уурхайн салбараа хөгжүүлэх гол бодлого бол эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал юм. Хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн улс орон хөгждөггүйг олон орнуудын жишээн дээр тулгуурлан тогтоосон байдаг.

Монгол Улсын эдийн засагт уул уурхайн салбарын хөгжил мэдээж эерэг нөлөө үзүүлэх нь гарцаагүй, гэхдээ бид энэ салбарыг болгоомжтой, удаан хугацаанд алгуур хөгжүүлэх нь чухал юм. Өөрөөр хэлбэл хэдхэн жилийн дотор улс орныхоо баялагийг гадаадын компаниудад олборлуулахгүйн тулд бодлогын хувьд нухацтай хандах хэрэгтэйг одоо ч эрдэмтэн судлаачид анхааруулсаар байгаа.

Уул уурхайн яамнаас “Төрөөс эрдэс баялгийн салбарын талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг УИХ-аар батлууллаа. Энэхүү бодлогын баримт бичиг төрөөс эрдэс баялгийн салбарт 2025 он хүртэл баримтлах бодлогыг тодорхойлох юм. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын баримт бичиг нь үндсэн 4 бүлэг, 14 хэсэг, 70 заалтаас бүрдэж байгаа ба эрдэс баялгийн салбарт баримтлах зарчмуудыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор эрх зүй, татварын орчны талаар аливаа шийдвэр гаргахдаа судалгаа, шинжилгээнд суурилж, оролцогч талуудын хууль ёсны эрх ашгийг хохироохгүй байх;

Олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлд байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих;

Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгж нээлттэй, ил тод, хариуцлагатай байх, хөрөнгө оруулагч нь хууль дээдлэх, харилцан ашигтай ажиллах, хэрэгжүүлэхэд төрөөс хөрөнгө оруулагчдад ижил тэнцүү нөхцөл олгож, өмчийн хэлбэрээр ялгаварлахгүй байх, компанийн сайн засаглалыг дэмжих;

Улсын болон хувийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байгаа бүх шатны геологийн судалгаа, олборлолт, боловсруулалтын ажлын талаарх хуулиар хориглоогүй мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй байлгах;

Эрдэс баялгийн салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, стандартыг олон улсын түвшинд хүргэж, хэрэгжилтийг хангах зэрэг болно.

Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журам, ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” хэрэгжсэнээр улсын эдийн засагт оруулах уул уурхайн салбарын өгөөж нэмэгдэж, эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын нэг цонхны бодлого бодитойгоор хэрэгжиж, эдийн засгийн хөгжил дан ганц нэг салбараас хамааралгүйгээр олон тулгуурт эдийн засгийн хөгжлийн үндэс бүрдэх юм.

²⁴ Монгол улсын Ундэсний статистикийн хороо. Тайлан 2013 оны 1-р улирал. 2013 оны 4-р сарын 1-нд нийтлэгдэв. www.nso.mn.

Үүнтэй зэрэгцэн уул уурхайн салбарын эрх зүйн орчны асуудал дахин түлхүү яригдаж, ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэх хуулийн төслийн хэлэлцүүлэг хийгдэж байгаа үетэй холбогдуулан энэ асуудлыг хөндөн тавих нь зайлшгүй асуудал болоод байна.

Өнөөдөр манайд уул уурхайн салбарт 34 хууль тогтоомж, 183 хэм хэмжээний акт, 295 стандарт үйлчилж байна²⁵. Эдгээрээс уул уурхайн салбарын гол хууль болох Ашигт малтмалын тухай хууль анх 1994 онд батлагдаж 3 жилийн хугацаанд хэрэгжин 1997 онд шинэчлэгдэн, 2006 онд одоогийн мөрдөж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан юм.

Энэ шинэчлэн найруулсан хуульд өмнөх хуулиас зарчмын ялгаатай олон зүйл, заалтууд орсон. Тухайлбал ашигт малтмалын ордыг стратегийн ач холбогдолтой, түгээмэл тархацтай, энгийн гэсэн ангилалтай болгож стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордыг ашиглахад хэний хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосноос үл хамаарч төрийн оролцоотой байхаар хуульчилсан.

Мөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөрийн хэмжээг нэмэгдүүлсэн, хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч Засгийн газрыг төлөөлж санхүү, геологи, уул уурхайн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах боломжтой болсон. Түүнчлэн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн.

Эдгээр хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, зөрчигдсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх бүхий этгээдүүд нь эрх бүхий улсын байцаагч болон тухайн орон нутгийн засаг дарга юм.

Эдгээр субъектүүдийн хуулиар олгогдсон эрх хэмжээ өргөн боловч харин хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих нь сул байгаа нь өнөөгийн бодит байдлаас харагдаж байгаа юм. 2013 явуулсан шалгалтаар байгаль орчныг хамгаалах бөлөвлөгөөний хэрэгжилтэнд өгсөн үнэлгээгээр нийт аж ахуйн нэгжийн 15.8% нь сайн, 36.8% нь хангалттай, 47.4% нь хангалтгүй гэж үнэлэгдсэн байна. Мөн байгаль орчны хяналт ойнжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэнд өгсөн үнэлгээгээр нийт аж ахуйн нэгжийн 10.5% нь найн үнэлгээ авч, 68.4% нь хангалтгүй үнэлгээ авчээ. Энэ нь хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага болон уул уурхайн компаниудын хууль, дүрэм, журмын хэрэгжилт сул байгаа нь харагдаж байна..

Монгол Улсын Засгийн газар сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд ашигт малтмалын лиценз олголтыг хязгаарлалт, хяналт нарийн тогтоолгүйгээр ихээр олгосноор «нийгмийн хариуцлага»-гүй гадаад, дотоодын уул уурхайн компаниуд олборлолт явуулахдаа тогтоосон хэмжээнээс хэтэрсэн химийн хорт бодис ашиглах, ашигт малтмал цэвэрлэсэн усаа голын урсгал руу шууд урсгах, үүнээс болж хүн, амьтан хордож, гол горьхи ширгэж, олборлолт явуулсан газартаа нөхөн сэргээлт хийхгүй орхих, овоолоод орхисон шороо, нүхэнд нь хүн, мал унаж осолдох явдлууд сүүлийн жилүүдэд эрүүгийн тоо бүртгэлд өссөн үзүүлэлт гарч байгаа нь энэ салбарт хуулийн хяналтыг чангатгах, эрх зүйн орчинг сайжруулах асуудал яригдах үндэс болсон юм.

Энэ үүднээс Монгол Улсын Загийн газар 2011 онд улсын хэмжээгээр усны тооллого явуулж, тайлан гаргасан байна²⁶. Уг тайланд Монгол улсын хэмжээнд нийт 5128 гол, горхи бүртгэгдсэнээс 852 нь ширгэсэн, 9306 булаг, шанд бүртгэгдсэнээс 2277 нь ширгэсэн, 3747 нуур, тойром бүртгэгдсэнээс 1181 нь ширгэсэн, 429 рашаан ус бүртгэгдсэнээс 60 нь ширгэсэн дүн гарсан байна. Энэ нь нэг талаас голын сав газрын хөрс, ургамал бүрхэвчийн өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлт, ноогөө талаас уул уурхайн буруу үйл ажиллагааны улмаас усны горим,

²⁵www.legalinfo.mn

²⁶Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны хэрэг эрхлэх газраас 4 жил тутамд улсын хэмжээнд усны тооллогыг явуулдаг. +2017 оны тооллого явуулж, тайлан гаргажээ. Усны хэрэг эрхлэх газрын 2011 онд явуулсан усны тоологын дүн. Өнөөдөр сонин. 2013 оны 7-р сарын 09-ны дугаар №286.

нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдэж байгаатай холбоотой юм. Баримт дурдахад Өвөрхангай аймгийн Цэнхэр сумын нутагт үйл ажиллагаагаа явуулдаг «Алтан дорнод», «Монгол газар» компаниуд тус сумын нутагт байрлах Орхон голын урсгал руу алт угаасан усаа урсгаснаас болж Орхон гол бүхэлдээ бохирдон, уг хэрэг өнөөг хүртэл шүүхээр шийдэгдээгүй байна.

Монгол Улсад одоогоор хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгт мэргэшсэн мөрдөгч, прокурор байхгүй бөгөөд, үүнтэй холбоотойгоор энэ гэмт хэргийн байгаль орчинд учруулсан бодит хохирлыг тогтоох, хэргийн газрын үзлэгийг нарийвчлан хийх, хэмжилтийг буруу хийх, нотлох баримтыг дутуу үнэлэх зэрэг хүндрэлүүд байгаа нь судалгааны явцад харагдаж байлаа.

Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргэгт явуулах мөрдөн шалгах ажиллагаа нь бусад гэмт хэргээс ялгагдах өвөрмөц онцлогтой бөгөөд, тэр дундаа байгаль орчинд учирсан бодит хохирлыг тогтоох асуудалд мэргэжлийн байгууллагын шинжээчдийг оролцуулан дүгнэлт гаргуулдаг, гэвч хэргийн нотолгоо нь дан ганц тэр дүгнэлт дээр тулгуурлаж хийгдсэн нь уншиж танилцсан эрүүгийн хэргүүдээс харагдаж байлаа. Эдгээр дүгнэлт нь зөвхөн байгаль орчны экологийн хохирлыг тогтоосон дүгнэлт гаргаж байгаа нь өрөөсгөл бөгөөд уг хэргийн шийдвэрлэхэд бодит нотлох баримт болж чадахгүй байна. Тиймээс энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд экологийн бодит хохирлыг эдийн засгийн тооцоон дээр бодитой тогтоох шаардлагатай юм. Үүний тулд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд мэргэшсэн шинжээчдийг байгуулах, түүнд шинэ алба хаагчдыг бэлтгэх талаар анхаарах цаг болжээ.

УСНЫ ХАЯГДАЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ

Б.Наргулан

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
багш, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга

Хүн амын өсөлт, үйлдвэрлэл, технологи хөгжил хүчин чадал, хотжих процесстэй уяалдан усны хэрэглээ жил бүр үлэмж нэмэгдэх болсон нь хот суурин, үйлдвэр аж ахуйн нэгж газраас гарах бохир усыг байгаль орчин хор хөнөөл үзүүлэхгүйгээр зайлуулах цэвэрлэх асуудыг чухлаар дэвшүүлэн тавьж байна. Бохир усны нөлөөгөөр хүрээлэн буй байгаль орчны тэнцвэрт байдал алдагдаж хүн, амьтан, ургамал хордож сүйрэх болсон нь ахуйн ба үйлдвэрлэлийн хэрэгцээнээс гарч буй хаягдал ус болоод түүнийг цэвэрлэж чадаагүйтэй шууд холбоотой болж байгаа ямар чухал ач холбогдолтой болох талаар энэхүү илтгэлдээ товчхон дурдсан болно.

Түлхүүр үгс

Хаягдал ус, бохир ус, хуйн бохир ус, үйлдвэрийн бохир ус, хур тундасны бохир ус

Үндсэн хэсэг

Монгол орны цэвэр усны дийлэнх хувь буюу 80 хувийг эзэлдэг гадаргын усны дийлэнх хувийг бохирдуулдаг байгууллага нь Уул уурхайн салбар тэр тусмаа алтны шороон орд гэж үзэж байна. Манайд ашигт малтмалын лицензтэй 1000 гаруй аж ахуйн нэгж, байгууллага байдаг. Үүнээс шороон ордны 200 гаруй аж ахуйн нэгж байдаг байна. Монгол орны хэмжээнд гадаргын усны асуудал өнөөгийн байдлаар хамгийн хүнд асуудлууд болж байна. Яагаад гэвэл шороон ордны хяналтгүй, замбраагүй хэрэглээ нь Монгол орны томоохон олон голыг бохирдуулсаар байна. Өнөөгийн байдлаар хамгийн том жишээ бол Хамгийн сүүлийн үеийн өнгөргөгч оны мэдээгээр 852 гол горхи, 2277 булаг шанд, 1181 нуур тойром ширгэсэн байна.

Үүнээс хамгийн том жишээ бол: Эртний түүхт Орхон гол усаар биш улаан шороогоор уйлан урсч, голын эх ундарга дээр “Монгол газар” компани 6 жилийн өмнөөс алт олборлолт явуулж, байгалийн нөхөн сэргээлт хийлгүй байсаар хиймэл нуурууд нь далангаа сэтэлж, химийн хүнд элементүүд Орхон голд цутгаж эхэлж байна. Орхон гол нь 5 аймгийн 13 суманд хүрдэг 1124 км урт үргэлжлэх Монголын хамгийн урт гол юм. Орхон гол дамжин өнгөрдөг 5 аймгийн малчин, ард иргэд уух усгүй ангаж хатахин зовлон учирч байна.

Эдгээр асуудал нь хүн малын ундаалах усны хомсдол болоод хаягдал ус хэргэлсэн мал амьтад төрөл бүрийн халдварт болон суурь өвчин үүссээр байна.

Монгол орны хэмжээнд хаягдал ус болоод хаягдал ус шинээр үүсгэж байгаа томоохон асуудлуудтай хурцаар тэмцэж эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага өнөөгийн хамгийн тулгамдсан асуудалын нэг болж байна. Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд өнгийн шинэ техник технологи боловсруулах тэдгээрт тавигдах шаардлагыг стандарчлах хэрэгтэй байна. Үүний тулд судалгаа шинжилгээг сайтар явуулан эдийн засгийн болоод хөдөлмөрийн бүтээмж зэргийг тооцоолон бодож гаргаж үрэх нь зүйтэй байна.

Цаашлаад уг санаа санаачлагыг дэмжиж Монгол орны ирээдүйн хувь заяаны асуудал ирээдүйдээ зориулах том хөрөнгө оруулалт болж байна.

Судалгааны арга зүй: Усны өнөөгийн байдал

Дэлхийн усны 97,14% далай тэнгэсийн ус, 2,59% нь цэнгэг буюу ундны ус эзэлдэг. Нуурын усны 48%-г давс эзэлдэг. Манай гариг дээрх ус нь хатуу, хий, шингэн төлөвт орших бөгөөд нийт усны хэмжээ $1,38 \cdot 10^{18}$ тн гэж үздэг. Үүнээс шингэн төлөвт ус 98% хатуу төлөвт ус 2% уурын буюу хий төлөвт ус ойролцоогоор 0,001% байдаг. Монгол орны усны нөөцийг “Сав газрын зөвлөлүүдийн анхдугаар чуулган”-ы эмхтгэлээс үзэхэд Монгол орны усны нийт нөөц сүүлийн 40 жил хийсэн судалгааны дүнгээр 608,000 сая шоо метр хүрч байгаа бөгөөд үүнийг дараах байдлаар хувааж үзэж болох юм.

- 34,600 сая шоо метр нь гол мөрөн,
- 500,000 сая шоо метр нуур,
- 62,900 сая шоо метр мөнх цас, мөсөн гол,
- 10,800 саяшоо метр нь газрын доорх усны нөөц тус тус багтана.

Харин Монгол орны минь цэвэр усны нийт 80 илүү хувь нь газрын гадаргын буюу гол, мөрөн, нуур, рашаан, булаг гэх мэтээр байдаг байна. Тиймээс ч Монгол орныг цэвэр усны нөөц багатай улс орнуудын тоонд орж байгаа юм.

Хаягдал ус гэж юу вэ?

Усны бохирдол гэж хүний шууд ба шууд бус үйл ажиллагааны улмаас байгалийн усны найрлага өөрчлөгдөж, усны чанар доройтохыг.

Бохирдуулах бодис гэж хаягдал усанд агуулагдаж, хүрээлэн байгаа орчныг бохирдуулж байгаа бодис, тэдгээрийн хольцыг.

Хаягдал ус гэж ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарч байгаа бохир ус, шингэн хаягдлыг.

Ус бохирдуулагч гэж ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж, хаягдал ус гаргаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг гэж Монгол улсын Хууль тогтоомжинд зааж өгсөн байна.²⁷

Бохир усны тухай ойлголт

Бохир ус: Ахуйн ба үйлдвэрийн технологийн хэрэгцээнд хэрэглэгдэж түүнийхээ дүнд өөрийн анхдагч химийн бүрэлдэхүүн ба физик шинжээр өөрчлөн бохирдсон ус, мөн тухайн газар нутаг дээр буусан хур тунадасны ус хамаарна. Үүний үндсэн бохирдол нь хүн ба амьтаны янз бүрийн ялгадас, хүнсний бүтээгдэхүүний хаягдал, угаалгын бохир, үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглагдаж гарах бохир ус зэрэг байна.

Усны биологийн бохирдуулагчдад: патегон бактери, шимэгч хорхой, вирусыг хамруулдаг.

Химийн бохирдуулагчдад: нитрат, хартугалга, мишьяк, цацрагт идэвхт нэгдлүүд ордог.

²⁷Усны тухай хууль 2-р зүйл

Физик бохирдуулагчдын түгээмэл хэлбэр нь дулаан усны температур хэдэн хэмээр нэмэгдэхэд өөрчлөлт ордог.

Бохир усыг гарал үүслээр нь 3 төрөлд хуваадаг.

Ахуйн бохир ус: Олон нийт, орон сууц, үйлдвэр аж ахуйн газарт тоноглогдсон угаагуур, шүршүүр, онгоц, суултуур болон бусад сан техникийн төхөөрөмжүүдээр дамжин гарах бохир ус.

Үйлдвэрийн бохир ус: Үйлдвэрийн төрөл бүрийн технологит ашиглагдсан ус. Үйлдвэрийн технологийн хэрэгцээ болон хэрэглэж байгаа түүхий эдээс хамааран гарч байгаа ус.

Хур тунадасны ус: Бороо, хайлсан цасны ус барилгын дээвэр, зам, талбай, гудамж дээр бууж түүн дээрх бохирдлыг авч урсан хамж үүссэн усыг энэ төрөлд хамааруулна. /үйлдвэрийн нутаг дэвсгэр дээр буусан хур тунадас нь түүний бүхий л бохирдлыг хаман урсдаг учир үйлдвэрийн бохир ус цэвэрлэдгийн адил цэвэрлэх шаардлагатай байдаг.

Хаягдал усыг хамгийн ихээр гаргаж байгаа газрууд

Монгол орны хэмжээнд хаягдал ус гарах болсон шалтгаан нөхцөлүүд нь ахуйн болон үйлдвэрлэл үйлчилгээний салбарууд нь усны зүй бус хэргэлээтэй мөн орчин үеийн техник технолог ашигдалдаггүйтэй шууд холбоотой. Хаягдал ус хамгийн ихээр гаргаж байгаа салбарууд:

Үүнд:

1. Хүнд, хөнгөн үйлдвэрүүд
2. Ахуйн хэрэглээнээс гарч буй бохир ус
3. Барилга, барилгын материалын үйлдвэрлэл
4. Хүнсний үйлдвэрлэл
5. Уул уурхайн үйлдвэрлэл
6. Эрчим хүчний үйлдвэрлэл
7. Мал ажахуй, газар тариалан
8. Хими, биологийн үйлдвэрлэл
9. Ус, усан орчинд амьтан, ургамал үржүүлэхэд
10. Ус ихээр бохирдуулдаг бусад үйлдвэрлэл үйлчилгээ гэж хувааж үзэж болно.

Үүнээс Монгол орны цэвэр усны дийлэнхи хувь буюу 80 хувийг эзэлдэг гадаргын усны дийлэнхи хувийг бохирдуулдаг байгууллага нь Уул уурхайн салбар тэр тусмаа алтны шороон орд гэж үзэж байна. Манайд ашигт малтмалын лицензтэй 1000 гаруй аж ахуйн нэгж, байгууллага байдаг. Үүнээс шороон ордны 200 гаруй аж ахуйн нэгж байдаг байна.

Алтны шороон орд ашиглалтын нөлөөгөөр бохирдсон голууд

Хүснэгт №1

д/д.	Аймгийн нэр	Сумын нэр	Голын нэр
1	Архангай	Цэнхэр	Бодонт
2	Увс	Түргэн	Ногоон усны булаг
3	Увс	Түргэн	Бургастайн гол
4	Увс	Улаангом	Гашуун гол
5	Төв	Заамар	Хайлаастайн булаг
6	Төв	Заамар	Туул, Баян гол
7	Төв	Батсүмбэр	Бургалтайн гол
8	Төв	Заамар	Урд дэнжийн булаг
9	Төв	Мөнгөнморьт	Хэрлэн гол
10	Төв	Мөнгөнморьт	Тэрэлж гол
11	Төв	Мөнгөнморьт	Жамбалын гол
12	Сэлэнгэ	Баянгол	Тариатын гол
13	Сэлэнгэ	Ерөө	Бүхлээ гол
14	Сэлэнгэ	Ерөө	Ерөө гол
15	Сэлэнгэ	Ерөө	Могойн гол
16	Сэлэнгэ	Мандал	Балжийн булаг
17	Сэлэнгэ	Орхон	Хар нүдэнгийн булаг

18	Сэлэнгэ	Сайхан	Хондоолойн шанд
19	Сэлэнгэ	Орхон	Турлиахын булаг
20	Сэлэнгэ	Ерөө	Харганат гол
21	Өвөрхангай	Бат-Өлзийт	Зvvv сөтгөйн гол
22	Өвөрхангай	Бат-Өлзийт	Хонгилтын гол
23	Баянхонгор	Гурванбулаг	Өлзийтийн гол
24	Баянхонгор	Бөмбөгөр	Ширхэний булаг
25	Хэнтий	Цэнхэрмандал	Баян модны гол
26	Хэнтий	Батширээт	Гутайн гол
27	Хэнтий	Цэнхэрмандал	Хадагтайн булаг
28	Дархан-Уул	Орхон	Хараа гол

Дээрхи хүснэгтээс хархад гадаргын усны урсац сайтай байсан 28 гол хүн болоод мал амьтны хэрэгцээг хангахгүй болсон байна.

Хүн амын ахуйн хэрэгцээнд жилд 90.5 сая метр куб ус

Үйлдвэрт 222,3сая метр куб ус хэрэглэж,

60 гаруй хувь буюу 200 орчим сая м/куб бохир ус гаргаж байна.

Хамгийн сүүлийн үеийн өнгөрөгч оны мэдээгээр 852 гол горхи, 2277 булаг шанд, 1181 нуур тойром ширгэсэн байна. Үүнээс хамгийн том жишээ бол: Эртний түүхт Орхон гол усаар биш улаан шороогоор уйлан урсч, голын эх ундарга дээр “Монгол газар” компани 6 жилийн өмнөөс алт олборлолт явуулж, байгалийн нөхөн сэргээлт хийлгүй байсаар хиймэл нуурууд нь далангаа сэтэлж, химийн хүнд элементүүд Орхон голд цутгаж эхэлж байна. Орхон гол нь 5 аймгийн 13 суманд хүрдэг 1124 км урт үргэлжлэх Монголын хамгийн урт гол юм. Орхон гол дамжин өнгөрдөг 5 аймгийн малчин, ард иргэд уух усгүй ангаж хатахийн зовлон учирч байна.

Хаягдал усны хор уршиг

Хүн амын өсөлт, үйлдвэрлэл, технологи хөгжил хүчин чадал, хотжих процесстой уяалдан усны хэрэглээ жил бүр үлэмж нэмэгдэх болсон нь хот суурин, үйлдвэр аж ахуйн нэгж газраас гарах бохир усыг байгаль орчин хор хөнөөл үзүүлэхгүйгээр зайлуулах цэвэрлэх асуудыг чухлаар дэвшүүлэн тавьж байна. Бохир усны нөлөөгөөр хүрээлэн буй байгаль орчны тэнцвэрт байдал алдагдаж хүн, амьтан, ургамал хордож сүйрэх болсон нь ахуйн ба үйлдвэрлэлийн хэрэгцээнээс гарч буй хаягдал ус болоод түүнийг цэвэрлэж чадаагүйтэй шууд холбоотой болж байна.

Одоогийн байдлаар 200 гаруй суурин газрын усны нөөц баталгаажаагүй, төв суурин газарт оршин суугчдын 38% нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй усыг ахуй хэрэглээндээ хэрэглэж байгаатай холбоотойгоор хамгийн наад зах нь шүд цоорох, бамбай булчирхайн өвчнүүд цаашлаад ургийн гажиг дутуу тээлт, амьгүй төрөлтүүд бий болсоор байна. Энэ байдал нь цаашлаад Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд шууд болон шууд бусаар халдаж байгаа гэж үзэж болхоор байна. Түүнчлэн Эрүүл мэндийн яамнаас гаргасан судалгаанаас үзэхэд усны ерөнхий эрдэсжилтийг бууруулах 47 зөөлрүүлэх 27 магнийг бууруулах 99 сум байна гэсэн судалгаа гарчээ.

Монгол улсад хаягдал ус ашиглалт

Монгол улсад хаягдал усыг ашиглаж байгаа Цөөхөн газрын нэг нь газар тариалангийн салбар байна. Энэ нь тийм ч зөв санаа гэдэгт эргэлзэж байна. Учир нь газар тариалангийн хэмжээнд хэрэглэж байгаа хаягдал ус нь чухам ямар химийн элементээр баяжигдаж хаягдал ус болсныг судалж байгаа хүн цөөхөн байгаа байх. Манайх шиг буурай хөгжилтэй орноос хүнсний ногоо экспортолдог улс орон гэж байхгүй тийм болхоор уг бохирдсон усаар баяжигдсан ногоог өөрсдөө идэх болж байна. Өөрсдөө иднэ гэдэг нь мөн л тухайн химийн элементэд хордох болж байна.

Мөн Цахилгаан станцны Үнс барих явцад гарсан хаягдал усыг дахин ашиглах тунхаг төхөөрөмж ашиглаж байна.

Хаягдал уснаас эрчим хүч гарган авах ажил эхлүүлээд удаж байна.

Үүнээс өөр байдлаар буюу хэргэлсэн усаа дахин хэрэглэх гэсэн хамгийн чухал асуудлыг анхаарах нь зүйтэй байна. Гадаргын усыг хамгийн ихээр бохирдуулагч байгууллагуудын үйл ажиллагаанд ашигласан усаа дахин ашиглаж байгаа уурхайг дэмжих мөн үсгүйгээр ашигт малтмал олборлох арга замыг хайх зэргээр ажил зохион байгуулах хэрэгтэй байна.

Үр дүн

Хаягдал усны асуудлаар Уул уурхайн болон тэр тусмаа шороон ордны уурхайн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж түүний хэрэглээ усны нөөц ашиглалтыг багасгаж цаашлаад цэвэр усны улсын нөөцийг хамгаалах хамгийн үр дүнтэй ажлуудын нэг болох юм. Хэлэлцүүлэх асуудлуудыг хэрэгжүүлснээр Ирээдүй минь баталгаажиж цангах ангах асуудлыг бүр мөсөн шийдвэрлэнэ.

Дүгнэлт

Шороон орд ашиглахад ус ашиглах стандарт боловсруулан гаргаж мөрдүүлэх түүнд тавих хяналтын тогтолцоог сайжруулах. “Шороон орд ашиглахад ус ашиглах стандарт” Шороон орд ашиглан олборлолт явуулж байгаа байгууллага нь Монгол улсын усны нөөцийн тодорхой хувийг ашиглах гэрээг **заавал** усны газраар батлуулсан стандартын дагуу хэрэглэх.

Хэрэглээний үндсэн төлбөрийг шоо метр бүрт газрын гадаргын усанд 150-1500, гүний усанд 10000 төгрөг болгон зөвшөөрсөн хэмжээнээс хэтэрсэн шоо метр бүрт үндсэн төлбөрийг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнийг төгрөгөөр торгох, учруулсан хохирлыг нь үндэслэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг эрүүгийн хуулинд шинээр заалт оруулж шийдвэрлэх, мөн үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгээрлэх зэргээр усны ерөнхий хэрэглээг зохицуулж болно. Эдгээр үнийн дүн нь улс орны эдийн засгийн байдлаас шалтгаалан нэмэх, хасах 100-200 төгрөгөөр тооцож болно.

Мөн бохирдуулсан усаа заавал ашиглах байдлаар нь олборлогчдыг 4 хуваан авч үзэн 20 хүртэл хувийг дахин ашиглаж байгаа бол ус ашигласан төлбөрийг 10 хувь хөнгөлөх, 40 хүртэл хувийг ашиглаж байгаа бол 20 хүртэл хувийг 60 хүртэл хувийг ашиглаж байгаа бол 30 хүртэл хувийг, 80 хүртэл хувийг ашигласан бол 40 хүртэл хувийг хасаж бодох зэргээр хөшүүргийн арга хэмжээг хэрэглэх.

Шинлэг технологи ашиглан усны хэрэглээг багасгаж буюу цэвэршүүлэх арга хэмжээ авч үйл ажиллагаагаа явуулж байгаа олборлогчийн усны төлбөрийг 10 хувь хасч тооцох улсын төсөвт төлөх татварын хэмжээнээс 5 хувиар хөнгөлөх зэргээр тогтоож өгч болно.

Эдгээр асуудлуудыг яагаад тусгах болсон бэ? Гэвэл: Монгол улсын хууль тогтоомж дүрэм, журам, стандартууд нь хэт нэг талийг баримталсан хэрэгжхэд төвөгтөй харилцан уялдаа холбоогүй боловсруулагддагтай холбоотой юм. Энэ байдлаар хөгрүүлэх болоод хүндрүүлэх нөхцөл байдлуудыг тусгасан стандарт боловсруулан мөрдөж чадсанаар

1. Байгалд ээлтэй технологи боловсруулсан иргэн байгууллагад түүнийг үйлдвэрлэх хэрэглээнд оруулах талаар нь дэмжлэг үзүүлэх урамшуулах.

Монгол улсын хэмжээний эрдэмтэн судлаач зохион бүтээгч бүхэн ХАЯГДАЛ УС цэвэрлэх түүнийг зүй зохистой ашиглах талаар шинэлэг санаа, санаачлага, шинэ бүтээл бүтээсэн тохиолдолд улсын төсвөөс нэг удаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож тухайн бүтээлийг үйлдвэрлэлд оруулах, хэрэглээнд нэвтрүүлэх талаар нь бүх талын туслалцаа үзүүлэх буюу улсын үйлдвэрт үйлвэрлүүлж олсон орлогын 30 хувь тогтмол олгож байх зэргээр эрдэмтэн судлаач зохион бүтээгч нарын хөдөлмөрийг зүй ёсоор үнлэж тэдгээрийн цаашид ажиллах эрч хүчтэй болгох замаар улсын хэмжээнд өрсөлдөөн бий болгох зэргээр чанартай сайн бүтээгдхүүнтэй болж ард иргэдийн нийгмийн баталгаа хангагдах, цаашлаад ард иргэдийн идэвхи боловсрол дээшилнэ.

Санал

1. Шороон орноос гарч байгаа хаягдал усны стандарт боловсруулан гаргаж мөрдүүлэх түүнд тавих хяналтын тогтолцоог сайжруулах.
2. Байгалд ээлтэй технологи боловсруулсан иргэн байгууллагад түүнийг үйлдвэрлэх хэрэглээнд оруулах талаар нь дэмжлэг үзүүлэх урамшуулах.

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЭДИЙН
ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ**

Б.Хулан

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн багш, цагдаагийн дэслэгч

Оршил

Татвар бол улсын эдийн засаг болон нийгмийг хөгжүүлэх талаар тавьж буй нийтлэг зорилгыг хэрэгжүүлэх, төрийн бодлогыг зохих түвшинд нь ажиллуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх үндсэн хэлбэр билээ.

Аливаа улс орны татварын бүтэц нь эдийн засгийн дүр зургийг тодорхойлж байдаг. Монгол Улсын татварын орлогын бүтэц нь шууд ба шууд бус татварын орлогоос бүрдэнэ. Шууд татварын орлогыг бүрдүүлдэг орлогод ААНОАТ, ХХОАТ, Өмчийн албан татваруудын орлогууд хамаарна. Харин шууд бус татварын орлогыг бүрдүүлдэг орлогод НӨАТ, ОАТ, Тусгай зориулалтын албан татвар, Гадаад худалдааны албан татвар, бусад татварын орлогууд хамаардаг.²⁸ Энэ судалгаагаар ХХОАТ-ын эдийн засаг дахь нөлөөллийг судлах юм.

Түлхүүр үг: ХХОАТ, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, хуулийн өөрчлөлт

ХХОАТ-ын төрөл, ангилал

Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ) нь хувь хүний хөдөлмөр эрхлэх, хөрөнгө түрээслүүлэх, хөрөнгө борлуулах зэрэг бүхий л орлогод ногдох албан татвар юм. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар энэхүү татварыг зохицуулна. Уг татварыг ногдуулахдаа мөн тухайн татвар төлөгч хувь хүний татвар ногдуулах орлогыг тодорхойлно.²⁹

Хувь хүний орлогын албан татварыг төр, ард түмний нэрийн өмнөөс цуглуулжтүүний зарцуулалтын талаар эргүүлэн тайлагнах, нөгөө талаар иргэний төртэй харьцахалбанүүрэгтэй холбон тайлбарладаг. Энэ татварыгнэвтрүүлсний ач холбогдол нь төсвийн орлогын чухал эх үүсвэр болж байгаа эсэхээртодорхойлогдох боловч үр ашиггүй татвар гэсэн шалтгаанаар ашиглахгүй байх ньховор байдаг. Хувь хүний орлогын албан татварын зорилго нь орлогыг дахин хуваарилах, зохицуулах замаар төсвийн орлогын нэг эх үүсвэр болгоход оршино.³⁰

Хувь хүний орлогыналбан татварын сайн тал нь: татвар төлөгчдийн бололцоочадварт тохируулах боломжтой, нөгөө талаас зах зээлийн үнийн тохиололд бусадтатварыг бодвол бага өртдөг. Сөрөг тал нь: татвар төлөгч бүр өөрийн бүхорлогыг бүртгэж тайланг бэлтгэж, татварын алба түүнийг нь хянаж төлбөрийг хүлээжавахад нэлээд хүндрэл чирэгдэл, зардал гаргадаг явдал юм.³¹

Хувь хүний орлогын албан татвар нь бусад татваруудын адил төсвийн орлогыг бүрдүүлэх, тэгш шударга байх, энгийн байх үр ашигтай байх, үндэсний давуу талыгхангах зарчмуудад үндэслэдэг. Хувь хүний орлогын албан татвар төлөгч хэн байхыгсонгон авах явдал чухал байдаг. Мөн энэ албан татварын чухал асуудлуудын нэг нь татвартхамааруулах орлогыг тодорхойлоход чиглэдэг.³²

Онолын үүднээс татвар төлөх орлого гэдэг нь тухайн жилд татвар төлөгчийн олсон бүх орлогын нийлбэр, төлөх татвар нь тэр нийлбэр дүнгийн тодорхой хувь байдаг. Татварын

²⁸Мөнх. Ш. “Татварын бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл” судалгааны ажил, 2009

²⁹ҮТЕГ-ын цахим хуудас, электрон эх үүсвэр: <http://mta.mn/pages/27>

³⁰Цэндмаа. Ч. “Хувь хүний орлогын албан татварыг боловсронгуй болгох нь” судалгааны ажил, 2010

³¹Цэндмаа. Ч. “Хувь хүний орлогын албан татварыг боловсронгуй болгох нь” судалгааны ажил, 2010

³²Мөнх. Ш. “Татварын бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл” судалгааны ажил, 2009

ногдуулан суутгаж авах, төсөвт төлүүлэх байдлаас нь хамааруулж орлогыг татварын эцсийн суутгалт ба дундын суутгалт орлого гэж ангилдаг.³³

Дундын суутгалт орлогод:

- ✓ ажил эрхлэлтийн орлого
- ✓ тэтгэвэр тэтгэмжийн орлого
- ✓ хөрөнгө борлуулсны орлого
- ✓ хөрөнгө түрээслүүлсний орлого хамаарна.

Дундын суутгалт орлогын хувьд татвар төлөгч нь өөрийн жилийн нийт орлого зарлагыг нэгтгэн бүртгэж татварын тайлан буюу иргэний орлого татвар тодорхойлох хуудсаар эцсийн тооцоог хийх бөгөөд энэ нь дараагийн жилд төлөх татварын хэмжээг тогтоох үндэслэл болж өгдөг.

Эцсийн суутгалт орлогод тусгайлсан хувиар татварыг ногдуулж эх үүсвэр дээр нь суутгал хийгддэг орлогууд хамаардаг. Тухайлбал, ногдол ашиг, зохиогчийн шагнал, хадгаламжийн хүүгийн орлого, уралдаан тэмцээний шагнал гэх мэт орлого багтдаг.³⁴ Дараах суутгалт орлогуудыг татварын орлогын тайлан, мэдээнд суутган нэршлээр тэмдэглэдэг.

- Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого \Суутган-1\
- Урлагийн тоглолт, спорт тэмцээний, ШУ бүтээл \Суутган-2\
- Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого \Суутган-3\
- Дундын суутгал - 3% \Суутган-4\³⁵

ХХОАТ-ын эдийн засагт үзүүлэх нөлөөлөлд хийсэн дүн шинжилгээ

Хувь хүний орлогын албан татварын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судлахын өмнө тус татварын өөрчлөлтөнд нөлөөлөх зарим үзүүлэлтүүдийг регрессээр дүгнэе.

Утгын хүснэгт №1

	ХХОАТ (Y)	Татвар төлөгчийн тоо /Суутган-1/ (X ₁)	Ажилгүйдлийн түвшин (X ₂)	ДНБ (X ₃)
2005	57,986.6	20,973	3.3	2,779,578.3
2006	76,973.6	22,685	3.2	3,714,952.9
2007	90,044.0	27,354	2.8	4,599,541.4
2008	116,208.4	32,654	2.8	6,555,569.4
2009	128,240.6	37,159	11.6	6,590,637.1
2010	160,944.5	46,159	9.9	9,756,588.4
2011	232,257.3	66,727	7.7	13,944,238.1
2012	346,635.7	75,079	8.2	16,688,419.6
2013	449,045.9	97,418	7.9	19,174,242.6
2014	507,864.6	114,097	7.9	21,937,159.4
2015	482,334.5	127,009	8.3	23,150,385.6
2016	523,410.0	131,982	8.6	23,935,853.7
2017	647,750.2	145,180	7.3	27,167,034.7

Эх сурвалж: www.nso.mn, www.mta.mn

Тэгшитгэлийн загвар, түүний тайлбар: $ХХОАТ = b_0 + b_1 * S1 - b_2 * Au + b_3 * GDP + e_i$

- b_0 - Загварын сул гишүүн. Уг коэффициент нь эерэг тоо байх ба загварт авч үзсэн хувьсагчид бүгд тогтмол байх үеийн хувь хүний орлогын албан татварын орлого
- b_1 - Суутган-1 татварын орлого хувь хүний орлогын албан татварт хамгийн их хувийг эзэлдэг тул энэ төрлийн татвар төлөгчдийн тоо өндөр байх нь тус татварын орлого их байхад өндөр ач холбогдолтой юм.

³³ Мөнх. Ш. “Татварын бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл” судалгааны ажил, 2009

³⁴ Мөнх. Ш. “Татварын бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл” судалгааны ажил, 2009

³⁵ Татварын орлогын гүйцэтгэлийн мэдээ, 2012

- b_2 - Ажилгүйдлийн түвшин болон хувь хүний орлогын албан татвар хоорондоо урвуу хамааралтай бөгөөд ажилгүйдлийн түвшин буурснаар ажил эрхлэгчдийн тоо өсч улмаар татвар төлөгчийн тоо нэмэгдэж татварын орлого өснө.
- b_3 - Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөх нь онолын хувьд тухайн улсын иргэдийн орлогын түвшин өссөнийг илэрхийлэх тул иргэдийн татвар төлөлтийн мөнгөн дүн нэмэгдэнэ.

ХХОАТ = 39.255389854 + 4.95317929449* Суутган1 - 2.38892317803* Ажилгүйдлийн түвшин + 0.00365018018053* ДНБ

Тэгшитгэлээс харахад ХХОАТ-т нөлөөлөх дээрх үзүүлэлтүүд тогтмол үед тус татвар 39,255 тэрбум.төгрөг байх бол Суутган-1 татвар төлөгчийн тоо 1 нэгжээр өсөхөд ХХОАТ 4,95-аар, ДНБ 1 нэгжээр өсөхөд 0,0036 нэгжээр өсөхөд нэгжээр тус тус өсдөг. Харин ажилгүйдлийн түвшин 1 хувиар өсөхөд хувь хүний орлогын албан татвар нь 2,3889 нэгжээр буурдаг байна.

Хувь хүний орлогын албан татварын эдийн засгийн нөлөөллийг судлахаа төсвийн орлого, татварын орлого, ДНБ-нд хувь хүний орлогын албан татвар хэрхэн нөлөөлөх, хамаарахыг регрессийн тэгшитгэл, EViews 6 программыг ашиглан тооцоолов.

Утгын хүснэгт 2

	Төсвийн орлого(Ү)	Татварын орлого (Ү)	ДНБ (Ү)	ХХОАТ (Х)
2005	837,858.3	692,206.5	2,779,578.3	57,986.6
2006	1,360,409.8	1,128,140.6	3,714,952.9	76,973.6
2007	1,880,488.9	1,502,309.9	4,599,541.4	90,044.0
2008	2,170,396.9	1,890,896.6	6,555,569.4	116,208.4
2009	1,993,995.6	1,620,549.6	6,590,637.1	128,240.6
2010	3,122,464.2	2,688,236.3	9,756,588.4	160,944.5
2011	4,227,178.1	3,668,307.8	13,944,238.1	232,257.3
2012	4,863,120.8	4,203,423.4	16,688,419.6	346,635.7
2013	5,940,067.0	5,072,793.3	19,174,242.6	449,045.9
2014	6,223,378.0	5,157,024.5	21,937,159.4	507,864.6
2015	5,983,397.7	5,118,979.4	23,150,385.6	482,334.5
2016	5,835,043.8	4,950,950.2	23,935,853.7	523,410.0
2017	7,922,488.8	6,302,609.8	27,167,034.7	647,750.2

Эх сурвалж: www.nso.mn, www.mta.mn

- ✓ Төсвийн орлого болон хувь хүний орлогын албан татварын хамаарал

$$\text{BudgetR} = b_0 + b_1 * \text{ХХОАТ} + e_i$$

$$\text{Төсвийн орлого} = 11.59497 + 0.733297 * \text{ХХОАТ}$$

- $R^2 = 0.213848$
- t-Statistics (2.92) (12.37)

Төсвийн орлогыг хувь хүний орлогын албан татвар нь 21,38%-аар тайлбарлах бөгөөд хувь хүний орлогын албан татвар 1 нэгжээр өсөхөд төсвийн орлого 0,73 нэгжээр өснө. Мөн тус хоёр үзүүлэлт нь хоорондоо эерэг хамааралтай. (дэлгэрэнгүй хавсралт 4)

- ✓ Татварын орлого болон хувь хүний орлогын албан татварын хамаарал

$$\text{TaxR} = b_0 + b_1 * \text{ХХОАТ} + e_i$$

$$\text{Татварын орлого} = 0.615888 + 9.844549 * \text{ХХОАТ}$$

$$R^2 = 0.937125$$

$$t\text{-Statistics (2.56) (10.92)}$$

Татварын орлогыг хувь хүний орлогын албан татвар нь 93,71%-аар тайлбарлах бөгөөд хувь хүний орлогын албан татвар 1 нэгжээр өсөхөд татварын орлого 9,84 нэгжээр өснө. (дэлгэрэнгүй хавсралт 5)

- ✓ Дотоодын нийт бүтээгдэхүүн болон хувь хүний орлогын албан татварын хамаарал

$$GDP=b_0+b_1*XXOAT+e_i$$

- ДНБ=1.498842+41.62458* XXOAT
- $R^2=0.912197$
- t-Statistics (1.92) (14.27)

Дотоодын нийт бүтээгдэхүүнийг хувь хүний орлогын албан татвар нь 91,22%-аар тайлбарлах бөгөөд хувь хүний орлогын албан татвар 1 нэгжээр өсөхөд дотоодын нийт бүтээгдэхүүн 41.6нэгжээр өснө. ДНБ-д ийнхүү өндөр хамааралтай байгаа нь хувийн цэвэр орлого нэмэгдэхийн хэрээр хувийн хэрэглээ өссөнийг илэрхийлж байна. (дэлгэрэнгүй хавсралт 6)

Дээрх судагааг товч дүгнэхэд сонгож авсан үзүүлэлтүүдэд хувь хүний орлогын албан татварын нөлөөлөл эерэг буюу эдгээр үзүүлэлтүүдийг өсгөх төлөвтэй байна.

Дүгнэлт

1993 оноос Хувь хүний орлогын албан татварын хуулийг анхлан боловсруулж мөрдсөнөөс хойш өнөөг хүртэл хэд хэдэн удаа өөрчилж ирсэн ба бодлогын чанартай хийгдсэн хамгийн томоохон шинэчлэл нь 2006 оны хуулийн өөрчлөлт байлаа. Түүнээс хойш 2017 оныг хүртэл зарим заалтанд өөрчлөлт орсон бөгөөд 2018 оноос дагаж мөрдөгдөж буй хувь хэмжээ болон хөнгөлөлтийн өөрчлөлт цаг үеэ мэдэрсэн өөрчлөлт байлаа.

- ✓ Хувь хүний орлогын албан татварын төрөл, ангилалыг нарийвчлан тусгасан.
- ✓ XXOAT-ын хуулинд 1993 оноос өнөөг хүртэл нийтдээ долоон удаа өөрчлөлт орохдоо 6 шатлалт байснаас одоогийн байдлаар 1 шатлалтай ба нэгдсэн нэг хувь хэмжээтэй болсон байна.
- ✓ Албан татвар ногдуулах орлогын төрлөөс “Малчин өрх, мал бүхий этгээдийн орлого” гэсэн заалтыг хасч чөлөөлөх орлогын төрөлд оруулсан.
- ✓ Өнөөг хүртэл тус хуулинд нийт 9 заалтыг хүчингүй болсонд тооцож, 2 заалтанд нэмэлт өөрчлөлт оруулж мөн 6 заалтыг нэмсэн байна.
- ✓ Хөнгөлөлтийн хэмжээ жилийн орлогоос 84,000 төгрөг байсныг шатлалтай болгож, бага орлоготой бол их хөнгөлөлт, их орлоготой бол бага хөнгөлөлт эдлэх зохицуулалт нэмсэн.

Энэ шинэтгэлийн гол цөм болох татварын жигд 10 хувийн бага хувь хэмжээ нь татварын системд шударга, үр ашигтай, энгийн байх зарчмыг гүйцэлдүүлж, татварын ачааллыг жигдрүүлснээр хувь хүмүүсийн орлого, хөрөнгөө нуух явдлыг бууруулж, татвараа тайлагнах, төлөх явц сайжирч, төсвийн орлого нэмэгдэнэ хэмээн тооцоолсон. Харин 2017 онд хуулийн энэ заалтанд өөрчлөлт орж шатлалтай болсон ч түүнийг хүчингүй болгож хөнгөлөлтийг шатлалтай болгосон нь тун оновчтой бодлого болсон.

Манай улсын төсвийн орлогын дийлэнх хувийг буюу 78-аас дээш хувийг татварын орлого дангаараа эзэлдэг. Хувь хүний орлогын албан татварын нийт татварын орлогод эзлэх дүн тогтвортой өсч 2017 онд 10,3 хувьд хүрсэн бөгөөд дийлэнх хэсгийг хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан татварын орлого эзэлж байгаа нь энэ үзүүлэлт тус татварын өөрчлөлтөнд хамгийн ихээр нөлөөллийг илэрхийлнэ. Тус татварт Суутган 1-ийн эзлэх дүн жил тутам өсч байгаа нь татвараа өөрсө тодорхойлон төлөх ёстой хувиараа бизнес, хөдөлмөр эрхлэгчдийн орлого нуугдмал хэлбэрт байгааг илтгэн харуулж байна.

Тус татварын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгааны үр дүнд хувь хүний орлогын албан татвар 1 нэгжээр өсөхөд төсвийн орлого 0,73 нэгжээр, татварын орлого 9,84 нэгжээр, дотоодын нийт бүтээгдэхүүн 41.6нэгжээр тус тус өснө. ДНБ-д ийнхүү өндөр хамааралтай байгаа нь хувийн цэвэр орлого нэмэгдэхийн хэрээр хувийн хэрэглээ өссөнийг илэрхийлж байна. Сонгож авсан үзүүлэлтүүдэд хувь хүний орлогын албан татварын нөлөөлөл эерэг буюу эдгээр үзүүлэлтүүдийг өсгөх төлөвтэй байна.

Санал

1. Хувь хүний татвар ногдох орлогын суурьт бусдаас /хуулийн этгээд болон хувь хүнээс/ үнэ төлбөргүй авсан бараа, ажил, үйлчилгээ, биет ба биет бус хөрөнгийн орлогыг хамруулахгүй байна. Үүний тод жишээ нь иргэд хооронд байр сууцаа шилжүүлэхдээ

татвараас зайлсхийхийн тулд бэлэглэлийн гэрээ үйлдэх явдал түгээмэл тохиолддог билээ. Энэ асуудлыг анхаарч холбогдох хуулинд заалт оруулах

2. Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах шагнал ергөн дэлгэр, түгээмэл болж, шагналын дүн ихээр есч, урлаг соёл, спортын тамирчид, хүмүүс нийгмийн ендер орлоготой давхаргад шилжих үзэгдэл ажиглагдаж байгаа тул тэдэнд ногдуулах татварын хувь хэмжээг 5 биш, бусадтай адилтган 10 хувь болгох нь шударга зарчимд нийцэх юм.
3. Монгол улсад байнга оршин суугч татвар төлөгч болон түүний Монгол улсад орлого татвараа тайлагнаж төлөх татварын жилийг нарийвчлан тодорхойлох
4. Татвар ногдуулах малын тооны доод хязгаарыг судалгааны үндсэн дээр тогтоон мал бүхий иргэн, малчин өрхийн татварыг сэргээх
5. Хөдөлмөр эрхлэлтийн орлого нь тус татварын орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг бөгөөд энэ үзүүлэлт жил ирэх тусам нэмэгдэж байгаа тул үүнээс бусад орлогын татварыг нарийвчлан, оновчтой, үр ашигтай болгох
6. Хувьцаа үнэт цаас болон хөдлөх үндсэн хөрөнгө борлуулсаны орлогод татвар ногдуулах асуудлыг тодорхой болгох
7. Иргэдийн татварын боловсролыг дээшлүүлэх болон ТЕГ-ын мэдээллийн ил тод байдал, татварын талаар олон нийтэд шаардлагатай, үнэн зөв, бүрэн гүйцэт, дэлгэрэнгүй мэдээллийг хүргэж байх

Ашигласан материалын жагсаалт

Ном, эмхэтгэл

1. Мөнх.Ш. 2009, “Татварын бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл” судалгааны ажил
2. Цэндмаа. Ч. 2010, “Хувь хүний орлогын албан татварыг боловсронгуй болгох нь” судалгааны ажил
3. Акжол. Б. 2013, “ХХОАТ-ын тайлан, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх асуудал” судалгааны ажил
4. Маралмаа. Ч. 2014, “Татварын бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөө” судалгааны ажил
5. УТЕГ, Хувь хүний орлогын албан татвар, УБ 2007
6. Алтанзаяа. Г. 2011, “Татварын бүртгэл”. УБ, хуудас 93-106
7. ТЕГ, Татвар төлөгчдөд зориулсан хөтөч цуврал, Монголтакс тин ХХК, УБ 2011
8. ТЕГ, Монгол улсын татварын статистикийн эмхэтгэл, Хөх Монгол принтинг ХХК, УБ 2012

Электрон эх үүсвэр

1. УТЕГ-ын цахим хуудас. <http://www.mta.mn>
2. Үндэсний статистикийн хороо, <http://www.nso.mn>
3. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <http://www.1212.mn>

**МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Д.Ариужин

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
ахлах багш, цагдаагийн ахлах дэслэгч

Мэдээллийн аюулгүй байдлыг зөвхөн төрийн байгууллага, Монгол Улсын дотоодын асуудлын хэмжээнд ойлгож болохгүй. Манай орны интернэтийн гадаад урсгалын хэмжээ 2010 оноос даруй 80 дахин нэмэгдсэн байна. Энэ нь гадаадаас интернэтээр дамжин ирэх халдлага, хортой код бидэнд нөлөөлөх эрсдэлийг 80 дахин нэмэгдүүлсэн гэж ойлгож болно.

Түүнчлэн Монгол Улсын дотоодын интернэтийн харилцан холболтын дэд бүтцийг байгуулаад нилээн хэдэн жил болж байна. Гэвч сүүлийн 5 жилийн хугацаанд ямар хэмжээний мэдээллийг гадагш алдсан, хортой код, халдлагын уршгаар хэдий хэмжээний хөрөнгийн алдагдал хүлээснийг нарийн тогтоох эрх зүй, технологи, аргачлал бий болоогүй байна.

Технологийн дэвшлээр манай орны хүүхэд залуус Social networking буюу нийгмийн сүлжээний вэб програм хангамжийг (тухайлбал facebook, myspace, biznetwork, twitter) ихээхэн ашиглах болсонтой холбоотой хувийн нууцаа алдах, зүй бус зүйлд уруу татагдах явдал газар авч байна.

Засгийн газар, Харилцаа холбооны зохицуулах хорооноос интернэтийн агуулга, вэб хуудсын агуулгад зохицуулалт, хяналтыг хийж байгаа боловч гадаад улсад байрлах зүй бус агуулгатай тэмцэж чадахгүй байна. Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар, Кибер довтолгоонтой тэмцэх баг хамтран 2008 оноос хойш интернэтийн аюулгүй байдлын судалгааг хийж байна. 2015 оны сүүлийн байдлаар зөвхөн нэг интернэтийн үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээгээр 500000 гаруй халдлага, хортой кодын дамжиж байгааг тогтоожээ.

Дээрхи халдлага, хортой кодын 60 гаруй хувийг АНУ, Европын холбооны улсууд, 25 орчим хувийг БНХАУ, 15 орчим хувийг бусад орнуудаас илгээж байна. Энэ нь дан ганц манай улсад мэдээллийн аюулгүй байдлын халдлага, хортой кодын идэвхижил ихсэж байгаа бус дэлхий даяр нэмэгдэж байгаа талаар Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU) сануулж байна.

Дэлхийн хэмжээнд кибер гэмт хэргийн нөхцөл байдал улам бүр хүнд болж зохион байгуулалт бүхий үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэл мэдээлэл, харилцаа холбооны технологийг гэмт үйлдэлдээ ашиглахын зэрэгцээ кибер терроризмын эрсдэл улам бүр нэмэгдсээр байна.

Түүнчлэн томоохон улс орнууд кибер дайн, кибер тагнуулын үйл ажиллагааг идэвхитэй явуулах болсон бөгөөд уг аюул заналаас хамгаалах, дайран довтлох шинэ технологи, хүний нөөцийг бэлтгэхэд их хэмжээний хөрөнгийг зарцуулж байна. Монгол Улсын 2010 оны Улсын төсвийн тухай хуулиар нийт 15 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг мэдээлэл, харилцаа холбооны чиглэлд хийсэн хэдий ч дээрхи төсвийн 3 хувийг мэдээллийн аюулгүй байдлын хангах ажилд зарцуулсан байгаа нь “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2010 онд санхүүжүүлэхээр тусгагдсан ажлын 10 хүрэхгүй хувьтай тэнцэж байна. 2015 оны байдлаар мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төсөвт суусан мөнгө 2010 оныхоос 60 хувь буурсан үзүүлэлттэй байгаа нь мэдээллийн аюулгүй байдалд өртөх нөхцөл боломжийг төр засаг, орон нутгийн байгууллагууд олгож байна.

Төрийн байгууллага Улсын нууц, байгууллагын нууц, иргэний хувийн нууцтай холбоотой их хэмжээний мэдээллийн цаасан болон цахим хэлбэрээр хадгалан, боловсруулдаг бөгөөд цаасан мэдээллийн нууцыг хангах асуудлаар хуульд нийцүүлэн боловсруулсан журмыг мөрдөж байна. Харин цахим хэлбэрт буй төрөл бүрийн нууц мэдээллийг хэрхэн боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглах, устгахтай холбоотой эрх зүйн, техникийн шийдлийг өнөөг хүртэл хэрэглээнд нэвтрүүлээгүй байна.

Тухайлбал, Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар програм хангамжийг лицензжүүлэх асуудал шийдвэрлэгддэггүй, зориулалтын серверийн өрөөгүй, байгууллагын хэмжээнд мэдээллийн технологи хариуцсан зөвхөн нэг ажилтантай, удирдлага мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдалд ач холбогдолгүй ханддаг нь харагдаж байна.

Төрийн 67 байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлын талаар 2010-2017 онд хийгдсэн судалгаанаас иш татвал:

- Мэдээллийн системийн тоног төхөөрөмжийн нийт гэмтлийн 35% нь цахилгааны хэлбэлзэл, доголдлоос үүдэлтэй ба систем унах, хатуу диск эвдрэх, тэжээлийн блок болон шилэн кабелийн хөрвүүлэгч шатах хохирол учруулж байна.
- Нийт байгууллагуудын 36% нь вирусны эсрэг програмгүй, 50% нь firewall /галт хана/ ашигладаггүй байна.
- Сүлжээний халдлага эсэргүүцэх системийг нийт байгууллагын 7% нь ашиглаж байна. Үлдсэн 62 төрийн захиргааны байгууллагууд мэдээллийн аюулгүй байдал хэрхэн зөрчигдөж байгаа талаар огт мэдээлэлгүй байна.
- Нийт байгууллагуудын 96% нь сервер, компьютер, сүлжээний төхөөрөмж, бусад техник хэрэгслээ даатгуулаагүй.
- Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 75% нь сүлжээ, системийн цоорхойгоо шалгаж скан хийдэггүй, 40% нь зориулалтын серверийн өрөөгүй байна.
- Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 98% нь програм хангамжийн албан ёснылицензгүй ашиглагдаж байна. Зөвхөн сервер болон хэрэглээний компьютерийн антивирусны програмууд л лицензтэй байна.
- Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын ихэнх хувь нь мэдээллийн аюулгүй байдлын талаар ойлголтгүй, тодорхой ажил эхлүүлээгүй, мэдээллийн системийг онцгой нөхцөлд сэргээх, кибер довтолгоонтой тэмцэх, мэдээллийн аюулгүй байдлын бодлого, стандартыг ажилтнууддаа танилцуулж мөрдүүлэх, сургалт зохион байгуулах зэрэг ажлууд хийдэггүй. Мөн хүний нөөцтэй холбоотой аюулгүй байдлын удирдлага байхгүй.
- Эд хөрөнгийн ангилал хийгдээгүй, хамгаалагдах эд хөрөнгийг нарийн тодруулаагүй. Хандалтын удирдлага сул, мэдээллийн систем суурилуулах, үйлчилгээ хийх удирдлага тодорхой хэмжээнд хэрэгжсэн. Мэдээллийн аюулгүй байдлын будлианы удирдлага байхгүй. Тасралтгүй ажиллагаа, сэргээн босох удирдлага байхгүй байсан нь мэдээллийн аюулгүй байдал хангалтгүй байна.
- Байгууллагуудын тал хувь нь нууцын асуудлыг зөвхөн Төрийн нууцын хуулиар зохицуулдаг, хуулинд заасан нууцлалд хамаарах мэдээллээс бусад мэдээллийг ангилаагүй, үнэлээгүй, үнэ цэнийг тогтоогоогүй, хандах эрхтэй холбоогүй, дийлэнх хувь нь Засгийн газрын тогтоолд заасан Кирилл ба Монгол үсгийн нэгдсэн кодын стандартыг мөрдөж ажиллаж байна.
- Хууль бус нэвтрэлтийг илрүүлэх бодлого, журам, механизм, техник хангамж, програм хангамж байхгүй учир илрүүлэх боломжгүй. Хууль бус нэвтрэлтийг илрүүлж чадахгүй учир мэдээлэл алдагдах, халдлага үйлдэх эрсдэл өндөр байна.
- Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 13 хувьд нь цахим хуудас халдлагад өртөж байсан бөгөөд халдлага хаанаас, хэзээ хийгдсэн талаар ямар ч мэдээлэл байхгүй байна.

КОНЦЕПЦИЯ И СОДЕРЖАНИЕ КОНСТИТУЦИИ МОНГОЛИИ О ПРАВАХ ГРАЖДАН НА ЖИЗНЬ В ЗДОРОВОЙ И БЕЗОПАСНОЙ СРЕДЕ

Д.Бадамцэцэг

ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, цагдаагий хошууч

Аннотация

Нами сделан анализ в концепции Конституции Монголии права и свободы человека, в том числе права жизни граждан в здоровой и безопасной среде и постарались объяснить их с точки зрения теории права и конституционного права в соответствии с международными правовыми нормами.

Ключевые слова

Права и свобода человека, конституция, право на жизнь в здоровой и безопасной среде

1. Основная часть.

Понятие о праве жизни в здоровой и безопасной среде, Основания Конституции

Право на жизнь в здоровой и безопасной среде представляет собой понятие невозможности человека жить без него с самого рождения как живое существо. Одним словом право на жизнь в здоровой, безопасной среде является обширным понятием, касающийся не только человека, но и животных, растения и окружающую среду.

Перед тем как рассмотреть концепцию конституции о данном праве следует рассмотреть понятие о здоровой и безопасной среде.

Понятие “здоровая среда” обычно связано с природным балансом и состоянием окружающей среды. К ним относятся воздух, вода, земля и связанные с ними природные и человеческие факторы.³⁶

Безопасная среда выражает понятия общественно-политического характера такие, как быть за исключением насилия, обеспечение общественного порядка, безопасность личности, вопросы обеспечения безопасности территории.³⁷

Требования права на жизнь в здоровой и безопасной среде, его связь с этапами развития прав человека делает ещё более открытыми содержание и сущность настоящего права.

Развитие прав человека делится на следующие этапы: К ним:

1. Эпоха развития гражданских и политических прав т.е “права первого этапа”. Установление порядка конституционализма и гарантия политических прав и свобод человека считаются первым этапом развития прав человека.

В эти времена в международных фактах о гражданских и политических правах человека и конституциях стран мира декларированы “личные” права человека, связанные с гражданским обществом как права на переписки, неприкосновенность жилища, печати, права выступить со словом, исповедовать и не исповедовать.

2. “Права второго этапа” развития прав человека т.е эпоха декларирования экономических и общественных прав. Данный этап развития прав человека охватывает начало и середину 20-ого века и были декларированы общественные, экономические и культурные права т.е права на защиту здоровья, труд и другие права, связанные с трудом, как получение заработной платы. Но они не были гарантированы в широкой сфере в конституциях стран мира как политические права.

[³⁶Краткий толковый словарь прав человека. НКПЧ, 2012г.стр135]

[³⁷Там же]

3. “Права третьего этапа” развития прав человека т.е эпоха прав окружающей человека среды и культурного развития. В отношении времени охватывает эпоху с середины 20-ого века до сегодняшних дней и к нему принадлежат права жить в здоровой, безопасной среде и права культурного, политического, экономического развития. Этими правами пользуются все вместе в пользу интересов каждого члена и поэтому называются совместными правами.

Условием необходимого возникновения права на жизнь в здоровой и безопасной среде являются влияние индустриализма, развитие науки и техники, глобализация, сопутствующие развитие индустриального общества и цивилизацию.

Производственные отбросы, последствия второй мировой войны, загрязнение воды и воздуха, дефицит зеленых сооружений, питьевой воды, изменение климата, политика “бурной экономики” и опустынивание стали проблемами, непосредственно принадлежащими к правам человека жить в здоровой и безопасной среде. В основном требование защиты права человека на жизнь в здоровой и безопасной среде берет начало от загрязнения окружающей среды, охватывающей весь мир и от кризисов, связанных с ним.

Напр: В 1967 году погибло множество морских животных и 15 тыс. птиц из-за того, что перевозное судно Торри Канион разливало в южной части Англии большого количества нефти³⁸, бедствие, связанное с загрязнением реки Куахаго³⁹ в США в 1969 году привлекали внимание всего мира и всем человечеством были признаны требования создания правовых регулираний, направленных на формирование здоровой, безопасной среды.

В то время негативные последствия ухудшения окружающей среды, уровень общественного сознания не были достаточно прогрессивными, которые могут влиять на утверждение внесения экологических вопросов в эти договоры и соглашения, а американский биолог Рачел Карсон впервые упомянул о необходимости правового регулирования в книге “Бесшумная весна”, которая была издана в 1962 г.⁴⁰ В течение тысячи лет права и обязанности, связанные с окружающей средой стали опорой Конституции, идея права на жизнь в здоровой, безопасной среде не была отражена в прямом смысле во “Всеобщей декларации прав человека”/1948/, “Международном факте о гражданских и политических правах”/1966/,⁴¹ “Международном факте об экономических, общественных и культурных правах”/1966/, может быть это связано с тем, что негативные последствия ухудшения окружающей среды и уровень общественного сознания не были достаточно прогрессивными, которые могут влиять на утверждение внесения экологических вопросов в эти договоры и соглашения.

В июне 1972г. состоялся Форум ООН по теме окружающей человека среды в столице Швеции Стокгольме и принята “Декларация Стокгольма об окружающей человека среде”.

Настоящая декларация считается первым правовым документом, где была положена основа права на жизнь в здоровой и безопасной среде.

В первом фундаментальном принципе декларации указано, что “Человек имеет основное право на свободу, равенство и благоприятные условия жизни в окружающей среде, качество которой позволяет вести достойную и процветающую жизнь, и несет главную ответственность за охрану и улучшение окружающей среды на благо нынешнего и будущих поколений”. За четыре года с утверждения Декларации Стокгольма, идея права на жизнь в здоровой среде со скоростью была распространена во всем мире. По состоянию 2012 года из 193 стран- членов ООН 177 странами признано данное право человека через их конституции, законодательство о природе и окружающей среде, судебные решения и международные законодательные акты.

[³⁸Брошюр “Право на жизнь в здоровой, безопасной среде”, изданный Национальной комиссией прав человека Монголии, Агентством Швейцарского развития]

[³⁹Там же]

[⁴⁰The Enviromental Rights Revolution: Constitutions. Human Rights. And Enviroment by David Richard Boyd, 2010 The British University of British Columbia]

[⁴¹ Считают, что в “Международном факте об экономических, общественных и культурных правах” каждому государству обязывает “улучшить гигиену окружающей среды и производства” стало первым сигналом появления права на жизнь в здоровой и безопасной среде.]

Право на жизнь в здоровой и безопасной среде развивалось через следующие этапы развития. К ним:

1. Первый этап т.е эпоха, в которой признано право человека на международном уровне/1945-1972гг./ 29 июня 1945 г. в Сан- Франциско США впервые было организовано обсуждение по охране окружающей среды и 10 декабря 1945 г. ООН была принята Всеобщая декларация прав человека.

2. Второй этап т.е эпоха конституализации./1972-1992 гг./

Каждое государство в своих конституциях декларировало право человека на жизнь в здоровой и безопасной среде. В связи с принятием “Декларации Стокгольма об окружающей человека среде” 1972 г. государства мира отразили в своих конституциях статьи об обеспечении права на жизнь в здоровой и безопасной среде, об обеспечении экологической безопасности окружающей среды и были приняты самостоятельные законы. Напр: Португалия в 1976 г., Испания в 1978 г., Турция в 1988 г. в своих конституциях закрепили, что “среда, в которой живут граждане должна быть благоприятной для человеческой жизни и граждане имеют право на жизнь в здоровой и безопасной среде”. В 80-ых годах в Болгарии, Венгрии и Польше уже были приняты комплексные законы об охране природы и окружающей среды.⁴²

Но эти законы регулировали вопросы, связанные только с охраной окружающей среды и не были самостоятельными законами, узаконившими право на жизнь в здоровой и безопасной среде. В это время в конституциях более 40 стран мира было определено право на жизнь в здоровой и безопасной среде и была узаконивана обязанность государства охраны природы и окружающей среды.

3. Третий этап т.е эпоха принятия самостоятельных законов об обеспечении права на жизнь в здоровой и безопасной среде./1992-2002гг./

В 1992 году в городе Рио Де Жанейро Бразилии состоялся форум “Окружающая среда и развитие” ООН и принят документ с 27 статьями под названием “Декларация Рио” и в первом из данных принципов было декларировано, что “Человек должен быть в центре обеспечения стабильного развития”.

Согласно этому принципу 68 стран мира в своих Конституциях и в профильных законах узаконивали данное право.

4. Четвертый этап т.е эпоха определения права на жизнь в здоровой и безопасной среде как носитель стабильного развития. /2002-2012 гг./ В 2002 г. в городе Йохансбурге состоялся высший форум по вопросам стабильного развития и в принятой из него декларации разработан принцип “Справедливости природы и окружающей среды” и упомянули в нем о создании суда, самостоятельно решающего нарушения права на жизнь в здоровой и безопасной среде. В это время право на жизнь в здоровой и безопасной среде было узаконено в 28 государствах мира.

5. Пятый этап т.е эпоха декларирования обеспечения права на жизнь в здоровой и безопасной среде, как основа стабильного развития. /с 2012 г. до сего времени/ В июне 2012г. в городе Рио Де Жанейро состоялось заседание ООН в кругу программы “Рио+” и приняли Декларацию Рио. Настоящая декларация призвала к развитию “Зелёной экономики”. И ещё определены задачи ООН Тысячелетнего развития до 2030г. и в сентябре 2015 г. на 70 Высшем форуме Генеральной Ассамблеи утверждена программа, основное содержание которой является “Изменим Мать-Землю: Программа стабильного развития-2030”. Эти “Задачи стабильного развития” имеют 17 целей, 169 задач, более 300 показателей по направлению поддержки, улучшения общественно- экономического развития, охраны природы и окружающей среды. Три основных столбами стабильного развития являются экономика, общество и окружающая среда и государства утверждают свои концепции стабильного развития и определяют реализацию права на жизнь в здоровой и безопасной среде, опираясь на сегодняшние потребности и требования, в соответствии с целью определения будущей политики. Напр: в 2010г. государства Евросоюза утвердили и реализуют долгосрочную

[⁴²The Enviromental Rights Revolution: Constitutions. Human Rights. And Enviroment by David Richard Boyd, 2010 The British University of British Columbia]

политику “Европа 2020: Разумный, стабильный, доступный рост”, в 2008 г. Российская федерация “Концепцию общественно- экономического развития РФ до 2020г”, в 2013г., КНР долгосрочную политику “Китай- 2030”.

II. Концепция Конституции Монголии о правах на жизнь граждан в здоровой и безопасной среде В 16.2 Конституции Монголии узаконивана гарантия права граждан на жизнь в здоровой и безопасной среде и указано, что “право жить в здоровой, безопасной среде, быть защищенным от загрязнений окружающей среды и нарушений природного баланса”. В Монголии в 1924 г. была принята первая Конституция и в принятых в 1940, 1960 годах Конституциях в определенной мере были узакониваны права человека но не были указаны права на жизнь в здоровой, безопасной среде. В 1990 г. в Монголии развивалась демократическая революция и под её влиянием в 1992г. по новому утверждена Конституция, в которой впервые узакониваны экологические права человека и в ней указаны новейшие понятия права человека и граждан, возможности их реализации.⁴³

В работе “Концепция Конституции” заслуженного юриста Монголии, доктора, профессора Б.Чимида отражено, что “Почитание человека, обеспечение его свободы является одной из коренных концепций новой Конституции Монголии”⁴⁴ и концепцию Конституции о правах и свободах человека можно определить следующим образом:

1. В введении Конституции декларировано, что одной из приоритетных целей народа Монголии являются почитание права и свободы человека, справедливости и национального единства и впервые определили понятие права человека в отдельности от гражданских прав. И это показывает, что вся структура государства является механизмом, который служит для обеспечения прав и свобод человека.

2. Понятия о правах человека полностью соответствуют к глобальной концепции всемирного развития и указаны, что каждый гражданин имеет право жить в здоровой и безопасной среде. В результате того государства определили в своих законах свойство “Legitiment”, имеющееся в конституции любого государства. Одним словом узаконено, что права и свободы человека являются врожденными и неотъемлемыми от самого человека и это стало доказательством отказа от марксистской доктрины, что “государство предоставляет гражданам права и свободу”. Процесс узаконения всеобщих прав человека имеет значение тем, что узаконены все основные самореализующиеся права/ self executing/, которые непосредственно используются судебными и государственными органами, основные права, которые определяются законодателем или государством /non self executing/⁴⁵.

Права, которые указаны в 16.2 Конституции Монголии “жить в здоровой и безопасной среде”, в 16.6 “право на защиту своего здоровья” относятся к правам в определенных случаях невозможно непосредственно использовать.

3. В Конституции Монголии право жить в здоровой и безопасной среде не ограничено только гражданами Монголии, в ней “права и свободы человека” определены в широком смысле включая иностранных граждан и граждан без подданства и это соответствует принципу равноправия Всеобщей декларации прав человека.

4. Права и свободы человека имеют первоначальное свойство, но в связи с условиями обеспечения коренных интересов и национальной безопасности государства в определенных случаях могут разграничиваться. В 18.5 Конституции Монголии указано, что “Предоставляя иностранным гражданам и лицам без гражданства, находящимся на территории страны, возможность пользоваться основными правами и свободами граждан Монголии, указанными в статье шестнадцатой Конституции, в целях обеспечения национальной безопасности и безопасности населения, охраны общественного порядка законом могут быть установлены

[⁴³Из выступления кандидата юридических наук, бывшего члена ВГХ С. Тимура на открытии симпозиума “Право человека и национальная безопасность”. Материал международного симпозиума. 1996 г. стр 113.]

[⁴⁴Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал” тэргүүн дэвтэр УБ., 2004 он]

[⁴⁵“Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал” олон улсын симпозиумын баримт материал. Илтгэгч Швейцарийн Берний Их Сургуулийн доктор Ёорг Паул Мюллер”Үндсэн хуульт төрөөс хүний эрхийг хамгаалах тухай илтгэл” УБ.1996 он,101-р тал]

соответствующие ограничения в отношении прав человека, кроме неотъемлемых прав человека, предусмотренных в международных договорах, к которым присоединилась Монголия” и это выражает смысл, что права и свободы человека не являются неограниченной средой. В 19.3 Конституции Монголии предусмотрено, что “При осуществлении своих прав и свобод, человек не должен допускать нанесения ущерба национальной безопасности, правам и свободам других, нарушения общественного порядка.

5. В 2.14. указано, что “Все, кто законно проживает в Монголии, равноправны перед законом и судом. Дискриминация человека по национальности, этническому происхождению, языку, цвету кожи, возрасту, полу, социальному происхождению и положению в обществе, имущественному состоянию, занимаемой должности, вероисповеданию, убеждению и образованию не допустима. Каждый человек обладает правосубъектностью⁴⁶. В данной статье право человека жить в здоровой и безопасной среде рассмотрено в отрыве от традиционных сознаний, которые относились к правам человека с точки зрения идеологической и классовой позиции.

6. В 19.2 Конституции Монголии указано, что “В случае объявления чрезвычайного и военного положения права и свободы человека, указанные в Конституции и других законах, могут быть ограничены только законом. Причём этот ограничивающий закон не касается права на жизнь, свободы убеждений и совести, а также положений закона о запрещении пыток, негуманного, жестокого обращения в отношении кого бы то ни было” и особо подчеркнули основные права человека при чрезвычайных ситуациях и определили право человека жить в здоровой и безопасной среде как врожденное от природы правом.

7. В 10.3. Конституции Монголии указано, что “Международный договор Монголии с момента вступления в силу закона о ратификации или присоединении имеет ту же силу, что и внутренние законодательства”. Это стало важным шагом, который установил юридические основания того, что общепризнанные международные правовые нормы, принципы, договоры являются составной частью правовой системы нашей страны.

8. В Конституции Монголии указаны основные обязанности и долги граждан Монголии. Напр: В 17.1,2. Конституции Монголии указано “Гражданин Монголии, высоко почитая справедливость и гуманность, неукоснительно выполняет следующие основные обязанности:

1/ почитать, уважать и соблюдать Конституцию, другие законы;

2/ уважать честь, достоинство, права и законные интересы человека;

3/ платить установленные законом налоги;

4/ защищать родину, нести военную службу в соответствии с законом.

Труд, охрана своего здоровья, воспитание детей, защита окружающей среды являются долгом каждого гражданина.

9. В Конституции Монголии определено, что право жить в здоровой и безопасной среде зависит от реализации определенных прав, как получение информации, участие в принятии решений, обращение к суду и об этих правах указаны в 16.17. Конституции следующим образом: право на поиск и получение информации по любым вопросам, не относящимся к законодательно закрепленной государственной тайне⁴⁷, в 3.1. “В Монголии вся власть принадлежит народу. Монгольский народ осуществляет это право путем непосредственного участия в государственных делах, а также посредством избранных им же представительных органов государственной власти”⁴⁸.

10. В 19.1. Конституции Монголии указано, что “Государство несёт перед своими гражданами обязанность создать достаточные социально-экономические, правовые и иные гарантии для обеспечения прав и свобод человека, бороться с нарушениями прав и свобод человека, восстанавливать нарушенные права” и это определяет общепризнанные международные нормы,

[⁴⁶Төрийн мэдээлэл.УБ.,1992 №1.]

[⁴⁷там же]

[⁴⁸там же]

гражданское общество, независимый суд, распределение государственной власти, Конституционное государство, Rule of law, которые стали условием формирования и укрепления идеи правового государства, обеспечивающего права на жизнь в здоровой и безопасной среде.

Считаем, что 4-ая Конституция Монголии, принятая в 1992 году создавала возможность гарантированного обеспечения права на жизнь в здоровой и безопасной среде и возможность правового регулирования, соответствующего к мировой тенденции глобального развития.

II. Заключение

Подводим итоги о концепции права на жизнь в здоровой и безопасной среде , отраженной в Конституции Монголии:

Впервые в истории Монголии явление узаконивания в Конституции права на жизнь в здоровой и безопасной среде стало выражением значительных изменений в правовом сознании монголов .

Если рассмотрим правовые регулирования Конституции, настоящая Конституция стала законом, основанным на концепции гуманного, демократического общества, где закреплены не только права на жизнь в здоровой и безопасной среде, но и права и свободы, которые указаны во Всеобщей декларации прав человека, Международном факте о гражданских и политических правах, Международных фактах об экономических и культурных правах, которые стали общепризнанными нормами защиты прав человека на жизнь в здоровой и безопасной среде и прав окружающей человека среды.

3. Конституция Монголии, принятая в 1992 году полностью соответствует тенденции современного теоретического мышления о правах человека, признавая равноправие государства и гражданина, определяет право человека на жизнь в здоровой и безопасной среде в соответствии с идеи конституционализма.

Библиография

I. Законодательные акты монголии

Конституция монголии /гос.бюлл.уб.,1992.№1/

Конституция мнр 1924, 1940,1960 /конституционны бюллетень монголии.уб.,1998 г/

II. Учебники, учебные пособия, брошюр

Ред ж.амарсанаа “хүний эрхийн товч тайлбар толь” хэүк. 2012 он

Б.чимид “үндсэн хуулийн үзэл баримтлал” уб., 2004 он

“эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх” танилцуулга. Мухэүк, швейцарын хөгжлийн агентлаг уб., 2010 он

“хүний эрх ба үндэсний аюулгүй байдал” олон улсын симпозиумын баримт материал уб., 1996 он

III. Иностранные языки:

1. The enviromental rigths revolution: constitutions, human rights, and the enviroment by david richard boyd., 2010 the university of british columbia]

“ЭМПАТИЯ” МЭДРЭМЖ БИЕ ХҮНД ХЭРХЭН БИЙ БОЛДОГ ВЭ?

П.Цагаандарь

ХСИС-ийн Цагдаагийн

сургуулийн

ЦЭЗТ-ийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

Эмпатия - грек үгнээс гаралтай ба /сэтгэл, мэдрэмж, хүсэл/ гэсэн утгатай. Бусдын сэтгэл хөдлөл, зовлон, жаргалыг мэдрэн хуваалцах чадварыг хэлнэ. Энэхүү мэдрэмж нь хүний хөгжлийн яаг аль үе шатаас эхлэн хүнд үүсэн хөгжин бий болдог талаас судлаачид тайлбарлаж чадахгүй байгаа ч М.Hoffman-гэх судлаач судлахыг хичээсэн байна. Түүний судалгаанд бага насны хүүхдүүдийн оюун ухаан хөгжихийн хэрээр би ба би биш гэсэн ялгааг ойлгож эхлэх ба өөрийн сэтгэл санааны байдал болон бусдын сэтгэл санааны байдлыг мэдрэж, дүгнэж эхэлдэг байна. \4,8,10,\

М.Hoffman судлаач нь эмпати мэдрэмжийг үндсэн 4 үе шаттай гэж хуваан авч үзсэн:

1.Эхний үе шат (Глобальная эмпатия) энэ үе шат нь хүүхдийн нярай насанд бий болох ба өөрийгөө бусдаас ялгах чадваргүй үе юм. Хажууд нь байрлах нярай хүүхэд уйлахад түүнийг сонссон нярай хариу үйлдэл үзүүлж уйлах. \9,10\

2 Хоёр дахь үе шат (Эгоцентрическая эмпатия) 2 нас хүрсэн хүүдэд хүрээлэн байгаа юмс үзэгдэл, хүмүүсийн зан араншин, сэтгэл хөдөлгөөнийг даган дууриах, хүүхдийг уйлж байхад эцэг эх хэрхэн аргадаж байсан хүүхэд тэрхүү байдлыг давтан дууриаж өөрийнхөө эмпацийг илэрхийлдэг байна.

3. Гурав дахь үе шат (Сочувствие к переживаниям других)2-3 насны хүүхдүүд бусдад санаа зовох, хайрлах, мэдрэмж бий болж эхэлдэг байна. Хүүхэд өөрийн болон бусдын сэтгэлийг ойлгох өндөр мэдрэмжтэй нэгэн болон төлөвшдөг. Өөрийн үзэл бодол, сэтгэл хөдлөлөө үйл хөдлөл, биеийн хэлэмж болон үгээр илэрхийлж эхэлдэг байна. \7,8\

4. Дөрөв дахь үе шат (Сочувствие к общему состоянию другого человека)хүүхэд 9 нас хүрээд өөрийн дотоод ертөнцийн мэдрэмж дээр тулгуурлаж эхэлдэг байна. Тиймээс хүрээлэн байгаа хүмүүсийн сэтгэлийн дотоод шаналалыг өөрийн зовлон мэт тусган хүлээн авч мэдрэх чадвар бий болдог байна.

Мөн А.Bohart ба L.Greenbarg судлаачдын үзсэнээр эмпати буюу бусдыг мэдрэх мэдрэмж хүн болгонд үүсэн бий болох нь ойлгомжтой гарцаагүй зүйл болов ч, нийгэмтэй харилцаж бий болон урган гардаг нэг төрлийн бүтээгдэхүүн гэж үзжээ. Үүнээс үзэхэд эмпати төлөвших хамгийн гол хүчин зүйл бол гэр бүлийн харилцаа юм. \4\

M.Shaffertгэх судлаач эцэг эхийн хүмүүжлээс хүүхдийн эмпати мэдрэмж хэрхэн хөгжих боломжтойг судалсан байна. Эцэг эх, үр хүүхэд 2-ын дунд байх ёстой хайр халамж, дулаан уур амьсгал, буруу үйлдэл хийх болгонд хүүхдийг шийтгэх, захирангуй, тушаангуй харьцах нь бусдыг хайрлах, ойлгох, мэдрэмжийг үгүй хийж, нийгмийн эсрэг үйлдэл хийх гэмт хэрэгтэн бие хүн болох магадлал ихээхэн нэмэгдүүлэх магадлалтай гэж үзжээ.

Хүүхдийг ойлгон сонсож, хайрлах, түүнийг дэмжиж буруу үйлдлийг нь түүнд тайлбарлан ойлгуулж, шийтгэлээс холуур өсгөх нь түүнийг бусдад нээлттэй, гэр бүлийн дулаан уур амьсгалыг бий болгож чаддаг байна.

K.Bryant судлаач нь 7 дугаар ангийн охид хөвгүүдийн дунд судалгаа явуулсан байна. Энэхүү судалгааны үр дүнд, эмэгтэй хүмүүс нас нэмэх тусам эмэгтэйчүүд нэгнийгээ ойлгох чадвар улам нэмэгддэг бол харин эрэгтэй хүмүүс эсэргээрэй энэ мэдрэмж нь улам багасдаг байна.

Үүнийг илүү гүн судлахад 7 дугаар ангийн хүүхдүүдээс судалгааны үр дүнгээс хархад охид эсрэг хүйстэн болох хөвгүүдийг илүү их ойлгож, өмнөөс нь санаа зовж, өрөвддөг бол эрэгтэй хөвгүүд нэгэндээ эмпати мэдрэмж төрүүлэх буюу гадагшаа ил гаргах нь өөрийгөө ижил хүйстэн мэт харагдана гэж үздэг тул ил гаргахаас татгалздаг байна. Ийд ухамсартайгаар энэ мэдрэмжээ дардаг болхон нээлттэй санал асуулгаар илэрчээ.\5\

R.DymondL.Cottrelсудлаачид насанд хүрсэн бие хүний эмпати мэдрэмжийг судлахад. Эмпати мэдрэмж өндөртэй бие хүн өөдрөг үзэлтэй, уяан хатан зан чанартай, бусдын байдлыг сонирхох, хүмүүстэй харилцахдаа чөлөөтэй, өөртөө итгэлтэй, амьдралд хандах хандлага эерэг шинжүүд илэрсэн. Харин эмпати мэдрэмж багтай иргэд дотогшоо, биеэ хэт барьж, хорисон, хувиа хичээсэн, хүмүүстэй энгийн чөлөөтэй сэтгэлээсээ хандах чадвар дунд, бусдаас үнэнч байдлыг шаарддаг ч өөрсдөө тийм байх чадваргүй ба /ганц бие чононууд/ гэж дүнэсэн байна.\6,7\

Эмпати мэдрэмж бол бид бүхэнд байдаг бидний салшгүй нэг төрлийн сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмж юм. Бидний өссөн орчин, хүмүүжил болон бидний дотоод ертөнцийн мэдрэмж дээр тулгуурлан бусдыг хэрхэн хайрлах чадвар маань илэрч гардаг байна.

Ашигласан ном:

1. Гаврилова Т.П. Понятие эмпати в зарубежной психологий \сэтгэл зүйн асуудлууд\ 1975 №2 хуудас 147-157
2. Пономарева М.А.Эмпатия: Теория, диагностика, развитие: монография-Минск, 2006 он-76 хуудас
3. Adams G.Sex,age, and perceived competency as correlates of empathic ability in adolescence-1979-vol 14, №56,-P811-818
4. Bohart A.Empaty reconsidered. New direction in psychotherapy-Washington American psychological Association. 1997-215p.
5. Bryant K.An index of empathy for children and adolescents\ Child Development. 1982,-Vol.53-P.413-425
6. Cottrell L.The empathic responses a neglected field for research-1949-Vol.12-P.215-228
7. Davis M.Empathy a social psychological approach-1996.-44p.
8. Eisenberg N.the roots of prosocial behavior in children \ Cambridge university press-1989.-120p
9. Freeman E. The development of empathy in young children un search of a definition\ child study journal-1984, vol.13, №4,-P235-245
10. Hoffman M.Empathy and moral development: 2006-p.519.